

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл


2013. 06 сар. №12 (046)

www.mongolianeconomy.mn

Шинэ тоглогчийн өнгө

Зээлийн хүүгийн
түвшинг бууруулах нь

“ЕРӨНХИЙЛӨГЧ” НАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫГ ШИНЖИХҮЙ





PartnerDirect
Preferred

Since 1997

ITzone®

Accelerate Your Success

CRN
PRODUCTS
OF THE
YEAR
2012



Dell PowerEdge R720

ШИНЭ ҮЕИЙН ХҮЧИРХЭГ, УЯН ХАТАН РАК СЕРВЕР

2012 оны дэлхийн шилдэг серверээр шалгарсан Dell PowerEdge R720 –ийг танилцуулж байна. Виртуалчлалын бүхий л хэрэгцээ шаардлагыг хангах Dell® PowerEdge™ R720 төхөөрөмж нь өндөр хурдтай тооцоо, гүйцэтгэл хийх шаардлагатай програм хангамжуудад хамгийн тохиромжтой сервер юм. Процессор бүртээ 8 цөмийг агуулах Intel® Xeon® E5 – 2600 олон цөмт-процессортой энэхүү төхөөрөмж сервер бүрт оногдох виртуал серверийн тоо хэмжээг нэмэгдүүлж, асар өндөр хурдтай гүйцэтгэлийг хүргэнэ.

● 24 хүртэл тооны DIMM санах ойг суурилуулж, санах ойг 768GB хүртэл нэмэгдүүлэх

● GbE, 10GbE зэрэг онцгой хурд бүхий сүлжээний дэвшилтэт холболтуудаас сонгох

● 2 socket, 2 unit сервер

● Серверийн удирдлагыг физик байдлаар, виртуал орчинд, сүлжээгээр, бүр алсын зайнаас удирдах боломжтой

● Мэдээлэл устгагдах аюулаас сэргийлэх хос RAID технологитой

312424

www.itzone.mn

**РЕКЛАМ МЭДЭЭЛЭЛ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ
АНХНЫ ХОСОЛСОН ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

РЕКЛАМ ЗАР МЭДЭЭЛЭЛ ХОСОЛСОН
www.reclam6s.mn САЙТ ШИНЭЭР НЭЭГДЛЭЭ



Онлайн touchscreen, LCD дэлгэц

40 инчийн 6 ширхэг LCD дэлгэц болон Touchscreen дэлгэцийн багц нь Хаан банкны салбар, Номин их дэлгүүр, Everyday супермаркет, Боса худалдааны төвүүдэд тус тус байрлана.



Цаг хугацаа эдийн засгийн хувьд:

Зар мэдээлэл авахын тулд сонин хэвлэлд мөнгөө гарздалгүй өөртөө ойр байгаа онлайн Touchscreen дэлгэц, LCD дэлгэц байрласан банкны салбарууд, супермаркетуудаас авах боломжтой. Таны өгсөн зар мэдээлэл нь хоног хугацаа алдалгүй 10 минутын дотор 40 байршилд Touchscreen дэлгэц, LCD дэлгэц, www.reclam6s.mn сайтаар нэгэн зэрэг цацагдана.



Онцлог давуу тал:

Touchscreen болон LCD дэлгэц нь зар мэдээллийг төрөлжүүлэн хүргэх бөгөөд дэлгэц тус бүрээр Таны реклам зар сурталчилгаа зурган, видео, үгэн гэсэн ангилалаар цацагдана. Мөн та дурын интернэттэй газраас www.reclam6s.mn сайтаас төрөлжсөн зар мэдээллийг нэгтгэж үзэх боломжтой.

LCD Дэлгэц

Touch screen tv



TV1: Автомашин худалдааны зар

Бүх төрлийн автомашин , тос тосолгоо, сэлбэгийн худалдаа, түрээс гэх мэт...

TV2: Үл хөдлөх хөрөнгийн зар

Хашаа байшин, газар, хаус, шинэ хуучин орон сууцны худалдаа, түрээс гэх мэт...

TV3: Бүх төрлийн худалдааны зар

Аж ахуйн нэгж болон иргэдийн бизнес худалдаа, тоног төхөөрөмж, барилгын болон ахуйн бусад хэрэглээ гэх мэт...

TV4: Бүх төрлийн үйлчилгээний зар

Интерьер, Экстерьер, барилга, гоо сайхан, эмнэлэг, орчуулга, олсон гэсэн гэх мэт...

TV5: Банк, санхүүгийн зар

Банкны мэдээлэл, валютын ханш, зээл, хадгаламж ББСБ, Ломбард зээл олгох чөлөөлөх гэх мэт...

TV6: Ажлын байрны зар

Ажилд авна, ажил хайж байна, хамтарч ажиллана, сургалт боловсрол гэх мэт...

Хаяг:

Улаанбаатар хот - 28,
ш/х - 44/685, УБ-210664
Энхтайваны өргөн чөлөө - 17/3
Алтай центр, 6 давхарт 611 тоот

Вэб хаяг:

www.reclam6s.mn

Утас:

(976)-70100156; 91116586

Факс:

(976)-70100156

И-мэйл:

reclam6s@kharanga.mn



Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав /9409-2904/

Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

MONGOLIAN ECONOMY ЦАХИМ СЭТГҮҮЛ

www.mongolianeconomy.mn

Банкны засаглалын мөн чанар хаана явна вэ



Өсөлт гэдэг өөрөө сорилт



“Дотоод хүч”



БИЗНЕС

- 9 “Ерөнхийлөгч” нарын эдийн засгийн бодлогыг шинжихүй
- 11 Банкны засаглалын мөн чанар хаана явна вэ
- 13 Шинэ тоглогчийн өнгө
- 16 Өсөлт гэдэг өөрөө сорилт

ЭДИЙН ЗАСАГ

- 20 Зээлийн хүүгийн түвшинг бууруулах нь
- 22 Монголын эдийн засгийн төлөв бүрхэг байна
- 26 Хүнсээ цуглуулъя
- 28 Хятад хороололд яг л хятад хүн шиг мэдрэмж төрдөг
- 30 “Дотоод хүч”

УУЛУУРХАЙ

- 33 Дэлхийд зөвшөөрөгдөх алхам
- 36 Хөгжлийн зураглал

МОНГОЛД

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл энэ оны эхний таван сард 872 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 16.4 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарын өсөлт давамгайлж, алт, газрын тос зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хоёр дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



“Тавантолгойн чахилгаан станц” төслийн нийт санхүүжилтэд 600-800 сая ам.доллар шаардлагатай байгаагийн

1.9 сая ам.долларыг Хөгжлийн банкнаас олгоод байна. Эхний ээлжинд 50 сая ам.долларын санхүүжилтийг бондын эх үүсвэрээс олгох аж.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд барих олон улсын нисэх буудлын төсөл хэрэгжих шатандаа орлоо. Японы Засгийн газраас уг төслийг хэрэгжүүлэхэд жилийн 0.2 хувийн хүүтэй, 40 жилийн хугацаатай 28.8 тэрбум иенийн зээл олгосон билээ. Нисэх онгоцны буудлыг 2016 онд ашиглалтад оруулах юм.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв /ЭЗБӨЧСТ/ нь Швейцарийн Удирдлагын хөгжлийн хүрээлэн (IMD)-тэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын тусгай тайланг гурав дахь жилдээ бэлтгэн гаргаад байна. Тус төвийн ТУЗ-ийн дарга

П.Цагаан судалгааны дүнг тоймлохдоо “Манай өрсөлдөх чадвар өсч байна, гэхдээ удаан байна” гэлээ.

Дэлхийн Эдийн Засгийн форумаас гаргадаг “Дэлхийн мэдээллийн технологийн тайлан-2013” –д Монгол Улс нийт 144 улсаас 59 дүгээр байр эзэлжээ.




Монголбанк, Азийн хөгжлийн банк хамтран “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэхээр болжээ. Уг төсөл нь бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх, одоогийн дэд

бүтцийг өргөтгөх замаар мөнгөний бодлогын хэрэгжилт, хяналтыг сайжруулах юм байна.




Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 20 сая ам.долларыг Азийн хөгжлийн банкнаас гаргах аж.

Монгол Улсын Хөгжлийн банкны 2011 болон 2012 оны санхүүгийн тайланд олон улсын “Делоитт” компанийн Монгол Улс дахь албан ёсны салбар компани болох “Делоитт Онч Аудит” компани аудит хийж, дүгнэлт гаргажээ. Дүгнэлтэд өгүүлснээр Хөгжлийн банк нь олон улсын стандартыг хангаж, шударга ажиллаж байна гэсэн үнэлгээ авчээ.



Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл энэ оны таван сарын эцэст 146.4 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 35.5 тэрбум төгрөг буюу 32 хувиар өсчээ. Энэ нь өмнөх оныхоос 2.4 дахин өссөн үзүүлэлт юм. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл энэ оны эхний таван сард 318 тэрбум төгрөгт хүрч өссөн байна.

Худалдах орон сууцны олдоц, орон сууцны зээлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк


ДЭЛХИЙ ДАХИНД:



АНУ-ын ТЕГ-ын гишүүн асан Эдвард Сновден Үндэсний аюулгүй байдлын агентлаг (NSA)-ийн түрэмгий ажиглалтын талаарх мэдээллийг илчилсэн нь дэлхий нийтийг шуугиулав. NSA террорист сэжигтний талаар мэдээлэл олж авах зорилгоор олон иргэний утасны бичлэгийг цуглуулж, тэдний онлайн дахь үйлдлийг хянасан байна. Эдварт Сновден одоогоор Хонконгд нуугдаж байгаа аж.

Хоёр Солонгос

сүүлийн зургаан жилд анх удаа хэлэлцээрийн ширээнд суухаар болов. Хэлэлцээрт хоёр улсын хооронд байгуулж байсан гэрээ, хэлцлийг сэргээх талаар ярилцах аж. Өмнөд Солонгосын төлөөлөгчид хоёр улсын харилцааг сайжруулахын тулд итгэлцлийг аажмаар бий болгоно хэмээн найдаж буй.



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт эрчээ алдаж байна. Өнгөрсөн онд сүүлийн 13 жилд байгаагүйгээр удааширсан тус улсын эдийн засгийн

өсөлт энэ оны төлөвлөгөө болох 7.5 хувьд хүрэхгүй хэмээн шинжээчид санаа зовж буй. Тус улсын хамгийн том хоёр зах зээл болох АНУ, Европын холбоо руу чиглэсэн экспортын хэмжээ сүүлийн гурван сар дараалан унасан үзүүлэлттэй байна.

Японы эдийн засаг энэ оны эхний улирлын байдлаар нэг хувиар өссөн үзүүлэлттэй гарсан нь цаашид өсөх эерэг дохио болж байна. Тус улсын тайлан, тооцооны илүүдэл хоёр дахин нэмэгдэх болсноор хөрөнгө оруулагчид Японы хөрөнгийн зах зээл рүү хошуурах болжээ. Тухайлбал Nikkei 225 индекс нэг өдөрт 4.9 хувиар огцом өссөн зэрэг эерэг үзүүлэлт нь дефляцид автсан эдийн

засгаа эрчимжүүлэх тус улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй ажилд түлхэц болж байна.



Төв Европт олон мянган иргэнийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэсэн үерийн аюул нүүрлэв. Өнгөрсөн долоо хоногт усны түвшин огцом нэмэгдэж үерлэснээс олон арван хүний амь үрэгджээ. Усны түвшин буурах үед далан эвдэрснээр Элбе гол орчимд нөхцөл байдал хүндэрсэн төдийгүй цэвэрлэгээний ажлын зардал олон тэрбум еврогоор хэмжигдэж байгаа аж.

Их Британийн “British Gas” байгалийн хий олборлогч компанийг эзэмшдэг “Centrica” компани “Cuadrilla Resources” болон “AJ Lucas Group”-ийг хамтран эзэмшдэг Английн Ланкашайр дахь занарын хий олборлох “Bowland” лицензийн 25 хувийг 40 сая фунт стерлингээр худалдаж авахаар болжээ. “AJ Lucas Group” өнгөрсөн нэгдүгээр сараас эхлэн хөрөнгө оруулагч хайж байсан нь биелэлээ олж, улмаар эхний ээлжинд 40 сая, олборлолт, үнэлгээний ажилд 60 сая фунт стерлингийн санхүүжилт авахаар төлөвлөвлөсөн байна. Ордын зургаан хэсэгт хийх өрөмдлөгийн ажил ирэх онд эхлэх аж.



А.Амарсайханы булан



-Та манай сэтгүүлийн талаар болон тухайн нийтлэлтэй холбоотой санал зөвлөмж хэлнэ үү?

Тэнцвэр бол давуу тал

-Танай сэтгүүлийн давуу тал бол тэнцвэртэй байдал. Үүнийгээ хэзээд хадгалах хэрэгтэй. Тэр тусмаа эдийн засгийн мэргэжлийн сэтгүүлд тэнцвэртэй байдал бүр ч чухал. Олон нийтэд хүрч буй мэдээллийнхээ давс, хужрыг сайн тааруулж байгаарай. Одоогийн байр сууриа бататгаж, мэдээллээ улам чанаржуулах хэрэгтэй. Танай сэтгүүлд мэдээлэл хангалттай бий. Сэтгүүлийнхээ зураг болоод нийтлэлээ сонирхолтой байдлаар уншуулах, график, хүснэгтээ сонирхол татахуйц хэлбэрээр өгөх хэрэгтэй. Ойлгомжтой, тодорхой, бага зайд ихийг хэлсэн, цаг үеэ мэдэрсэн мэдээлэл илүү олон хүнд хүрнэ шүү дээ. Танай хамт олонд амжилт хүсье.

*О.Эрдэнэбулган
/Уул уурхайн яамны дэд сайд/*

Захиалгын хуудсаа хавсаргаарай

“Mongolian Economy” сэтгүүлийн ерөнхий дизайн, англи монгол хэл дээр гардаг нь надад таалагддаг. Нийтлэлүүд нь уншихад хялбар бичлэгтэй юм. Эрдэм шинжилгээний ажил шиг ишлэлээр дүүрсэн бус зохих газраа тохирох эх сурвалжаа “шигтгэдэг” нь сайшаамаар санагдлаа. Хэт өөрийнхөөрөө ярьсан байдаг тул миний хувьд ярилцлагыг нэг их таашаадаггүй. Сэтгүүлчдийн хувьд нийтлэл бичих цаг завгүй үедээ ярилцлагаар орлуулдаг. Үүнээс илүүтэй шаардлагатай хэсгүүдэд мэргэжилтнүүдийн үгийг ишлэж, сэтгүүлчийн тодорхой өнцгөөс бичсэн нийтлэлийг уншихыг би илүүд үздэг. Манайх одоогоор танай сэтгүүлийг захиалж амжаагүй ч байнга худалдан авч уншаад дараа нь байгууллагынхаа хүлээлгийн танхимд үлдээхээр олон хүн сонирхон уншдаг. Сэтгүүлийн хавтасны дотор талд хэвлэмэл болон цахим хувилбарын захиалгын талаарх мэдээллийг байрлуулах эсвэл захиалгын хуудсыг хавсаргах хэрэгтэй гэж бодож байна.

Марк Тассэ /Америкийн Монгол судлалын төвийн суурин төлөөлөгч/

“Чингис” бондоор мэдээллийн сан үүсгэх боломж байна

-Тогтсон, тодорхой булантай болох хэрэгтэй. Булан тогтмол байснаар уншигчдад хүлээлт үүснэ. Нэг асуудлыг олон талаас нь хөндөж, зөвхөн мэдээлэл олгохоос гадна мэдлэг түгээхэд мэргэжлийн сэтгүүл учраас анхаарах учиртай. Тухайлбал, танайд “Чингис” бондын талаарх мэдээллийн сан үүсгэх боломж байна. Мөн мэдээллээ тогтмолжуулах нь оновчтой. “Mongolian Economy” сэтгүүлийн буланг унших гэж уншигч танайд ханддаг байвал та бүхний амжилт. Тиймээс уншигчаа хөтлөх, тэдэнд хүссэн мэдээллийг нь олгоход тухайн салбарын хүмүүстэй нягт хамтран ажиллах хэрэгтэй болов уу. Нийгэмд хангалттай мэдээлэл бий. Ийм мэдээллээр ханасан орчинд илүү гүнзгий мэдлэг болох мэдээлэл чухал. Жишээ нь, татвар гээд булан нээлээ гэхэд олон талаас нь харж, хөндөж бичиж болохоор байна. Энэ нь эргээд танай уншигчдад мэдлэг болно. Мөн эдийн засгийн судалгаатай нийтлэл, өгүүлэл хомс байдаг. Бидний хамгийн сайн мэдэж байвал зохих татварын талаарх мэдээлэл нийгэмд жигд бус байна. Үүнийг танай сэтгүүл нөхөж, зөв ойлголт өгөх боломж нээлттэй байна. Тиймээс ерөнхий эдийн засгийн зарим асуудлыг түр орхиод тодорхой эдийн засагт шилжих хэрэгтэй.

Э.Батбаяр /Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга/

Сэтгүүлийн хувьд мэдээлэл сайн

-Бидний хувьд “Mongolian Economy” сэтгүүлийг унших дуртай. Үнэн зөв, өгөөжтэй мэдээлэлтэйгээс гадна Монголын эдийн засгийн асуудлуудыг өргөн хүрээнд хамарч чаддаг. Сэтгүүлчдийн хувьд эдийн засгийн хөгжил иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг ул суурьтай олон талаас нь бичдэг чадвартай.

Корали Геверс /Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч/

ЦАГ ҮЕ

“ЕРӨНХИЙЛӨГЧ” НАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫГ ШИНЖИХҮЙ

Б.ТОГТОХ

“Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” хэмээн Үндсэн хуульд заасан байдаг. Тиймээс Ерөнхийлөгч хуульд заасан эрх, үүргийнхээ дагуу дөрвөн жилээр төр улсаа жолооддог. Монголчууд төрийн тэргүүнээ сонгох түүхэн сонголтын өмнө ирлээ. Ерөнхийлөгчөө тодруулах сонгуулийн тов ч ойртсоор. Сонгох, сонгогдох эрхээ эдлэх эл өдөр хэн Ерөнхийлөгч болохоос Монгол Улсын ирэх дөрвөн жилийн хувь заяа хамаарна.

Ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдорж /АН/, Б.Бат-Эрдэнэ /МАН/, Н.Удвал /МАХН/-аас тус тус нэр дэвшиж байгаа. Улсын тэргүүн болохоор зэхэж буй тэдний мөрийн хөтөлбөр буюу гэрийн даалгаварт эдийн засаг талаас нь анхаарал хандуулъя. Үүнд, Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана, Хөрөнгийн зах зээлийн тогтолцоог олон улсын жишигт хүргэнэ, Ази, Европыг холбосон авто болон Төмөр замын сүлжээг бий болгоно гэсэн лут том зорилтууд дэвшүүлжээ.

СЭЗДС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн багш Ц.Батсүх “Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй аль ч нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр бүрэн дүүрэн хэрэгжлээ гэж үзэхэд цаана нь Засгийн газар эрх мэдлээ хуваах, зарим эрхээ Ерөнхийлөгчийн мэдэлд өгч байж мөрийн хөтөлбөр нь биелэхээр



Засгийн газар эрх мэдлээ хуваах, зарим эрхээ Ерөнхийлөгчийн мэдэлд өгч байж мөрийн хөтөлбөр нь биелэхээр байна

байна. Энэ удаагийн сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр Ерөнхийлөгчийн гэхээс илүүтэй намуудын мөрийн хөтөлбөр гэж үзэж болохоор байна” гэв. Ерөнхийлөгч бүгдийг шийдэх албагүй. Гэхдээ бүрэн эрхийнхээ хүрээнд асуудалд бодитой хандах учиртай. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, амлалт нийгэмд сөрөг хүлээлт үүсгэх эрсдэлтэй байдаг аж.

Уг нь Ерөнхийлөгч улс орны эдийн засгийн бодлогод шууд гар дүрэх эрхгүй. Гэтэл нэр дэвшигч нарын мөрийн хөтөлбөрт өнөөдөр Ерөнхийлөгч болчихвол маргааш нь эрх мэдлийнхээ хүрээнд шууд шийдчих юм шиг зорилтууд онцгойрч харагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, тоон дотор үсэг гэдэг шиг Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт туссан үг, өгүүлбэр Засгийн газрыг ажилгүй болгож мэдэх нь. Ерөнхийлөгчийн засаглалтай орны хувьд байж болох хувилбар

ч Парламентийн засаглалтай манайд тохирохгүй хэмээн судлаач нар учирлаж байна. “Хаалга андуурсан эдийн засгийн бодлогыг Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт тусгах учиргүй” гэж МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Л.Оюун тайлбарласан юм. Гэсэн ч нэр дэвшигч нар олон нийтийн анхаарлыг татахуйц эдийн засгийн том бодлогууд ярьж, иргэдийг “хошгоруулсаар” явна.

Бэлэн мөнгөний амлалтаас Шинэчлэлийн Засгийн газар татгалзсан. Тэгвэл уг Засгийн газартай хамтран төрийг залах Ерөнхийлөгчийн сонгууль бэлэн мөнгөний амлалтаар сурталчилгаагаа хийж байна. Жишээ нь, Оюутны 70 мянган төгрөгийг 100 мянга болгоно, тэтгэвэр тэтгэмж нэмнэ гэх мэт.

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн бусад төрийн тэргүүнээс ялгагдах нэг онцлог бол хэдийгээр улс төрийн аль нэг намаас сонгогддог боловч албан тушаалдаа орсон хойноо намаасаа ▶

▶ татгалздаг явдал. Ингэснээрээ улс төрийн өөр өөр ашиг сонирхол, улс төрийн тэмцлийн дүнд боловсруулсан хууль, бодлогод хараат бус, төвийг сахисан байр сууриар асуудалд хандах боломжийг өгдөг” хэмээн МУБИС-ийн ННФ-ын “Ерөнхийлөгчийн засаглалын сүүдэр” судалгаанд онцолжээ.

Ерөнхийлөгч улсаа төлөөлөх бүрэн эрхтэй. Түүнээс эдийн засгийн бодлогыг дангаар залах боломжгүй. Засгийн газарт өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар чиглэл өгөхөөс биш шийдвэр гаргалтад оролцдоггүй. Ерөнхийлөгч онц байдал зарлах, шагнаж урамшуулах, улсаа төлөөлөх, онцгой тохиолдолд бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, өршөөл үзүүлэх эрх дархтай. Эдгээрээс хэтэрсэн эдийн засгийн эрх мэдэл гэж байхгүй ажээ.

“Ерөнхийлөгчийн эрх мэдлийн талаар манай судлаачдын дунд янз бүрийн байр суурь бий. Үндсэн хуулиар олгосон эрх мэдэл нь явцуу, Парламент хэт давуу эрхтэй гэсэн ойлголт түгээмэл байдаг. Гэвч бодит улс төрийн үйл явцаас харахад Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь Парламентын засаглалтай улс орнуудын Ерөнхийлөгчийн нэгэн адил хянан тэнцвэржүүлэгч шинжтэй гэж үзэж болох юм” хэмээн МУБИС-ийн Нийгмийн Ухааны тэнхимийн багш Ц.Мөнхцэцэг хэллээ.

УИХ-д болон ард түмэндээ хандан Ерөнхийлөгч илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно. Тухайлбал, Тавантолгойн ордын асуудлаар Ерөнхийлөгч байр сууриа илэрхийлэх, чиг үүрэг өгөх нь эрх зүйн хувьд нээлттэй аж.

Төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлэх эрхтэй. Түүнээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах хэмжээний төрийн бодлогыг Ерөнхийлөгч тодорхойлдоггүй болохыг эрдэмтэн судлаачид хэлж байна.

Татварын тогтолцоог боловсронгуй болгох үүрэг ч Ерөнхийлөгчийн голлон хийх ажил биш. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд Ерөнхийлөгчийн оролцоо туйлаас чухал гэж үү гэсэн асуулт ч хариулт нэхсээр. Тэр тусмаа Парламентын засаглалтай манай орны нэр дэвшигчид Ерөнхийлөгчийн засаглалтай орны хэмжээнд асуудлыг эдийн засгийн утгаар өргөн харж байгааг нь сэтгэлгээний онцлог уу, эсвэл сэтгэлийн хөөрлөөр хандсан оноо авахыг хүссэн хуурай бодлого гэж үзэх үү. ■

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрөөс эдийн засгийн томоохон зорилтуудыг ишилвээс...

АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж:

-Төсвийн хөрөнгөөр гаднын бараа бүтээгдэхүүн худалдаж авахыг эрс хязгаарлах, улмаар хориглох бодлого баримтална. Төсвийн санхүүжилт, худалдан авалтаар зөвхөн дотоодын үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажлын байр, үйлчилгээг дэмжихийг зөв гэж үзнэ. Мөн хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүдэд энэ шаардлагыг тавина.

-Хөрөнгийн зах зээлийн хөгжил, тогтолцоог олон улсын жишигт хүргэнэ. Иргэдийнхээ нэрийн данс, ирээдүйд зориулсан хадгаламжийг уул уурхайн салбараас олж буй орлогод түшиглэж баталгаажуулахад анхаарна.

-Уул уурхай, мал аж ахуй, байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг түүхийгээр нь экспортлохыг хязгаарлана. Аливаа түүхийг эдийн засгийн үйлдвэрлэгчдэд нийлүүлэхийг урамшуулна. Нэмүү өртөг шингээж, боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн хийж худалдаалахыг дэмжинэ. Үндэсний экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ...

МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ:

-Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчноо хамгаалах бодлогыг тэнцвэртэй байлгахад бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

-Эрчим хүч, шатахууны хараат байдлыг багасгах, үнийг зохистой хэмжээнд барих зорилгоор газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байгуулахыг чухалд үзнэ.

-Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр орлогын хуваарилалт, дахин хуваарилалт, татварын тогтолцоог боловсронгуй болгох бодлого явуулна...

МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал:

-БНХАУ, ОХУ-тай түүхэн уламжлалт найрамдалт харилцаагаа эдийн засгийн харилцаагаар баяжуулж, гурав дахь хөршийн бодлогыг улам бүр өргөжүүлнэ. Түүхийг эд нийлүүлэх урт хугацааны гэрээ хэлцлийг улс орнуудтай байгуулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

-Гадаадын хөрөнгө оруулалтыг харилцан ашигтай, шударга байх зарчмыг баримтлахын сацуу дотоодын хөрөнгө оруулагчиддаа давуу байдал олгодог болно.

-Ашигт малтмал, газрын баялаг тэр дундаа Тавантолгой, Оюутолгой болон бусад стратегийн ордуудыг ард түмэндээ хамгийн ашигтай хувилбараар шийдвэрлүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ...

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БАНКНЫ ЗАСАГЛАЛЫН МӨН ЧАНАР ХААНА ЯВНА ВЭ

Б.БАЯРТОГТОХ

“Монгол Улсад өнгөрсөн 22 жилийн хугацаанд 30 банк дампуурчээ”

Монгол Улсад 60 мянга гаруй компани, аж ахуйн нэгж бий. Эдгээрийн дотор 14 байгууллага арилжааны банкны тусгай зөвшөөрөлтэй. Тэд санхүүгийн салбарын 97 хувийг бүрдүүлж, ДНБ-ий 80-90 орчим хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг эргэлдүүлж байна. Өнөөдөр манай улсын ДНБ 14 их наяд төгрөгт хүрсэн бол банкны салбарын нийт хөрөнгө 10 их наяд.

Хөрөнгийн зах зээлийн хөшүүн байдлаас тэс өөр хөгжлийн загвараар арилжааны банкууд замнасан. Энэ нь өнөөдрийн санхүүгийн зах зээлийг эзэгнэхүүдийг нээсэн гэхэд хилсдэхгүй. Банкны салбар оршин тогтнох цорын ганц баталгаа нь засаглал. Засаглал хэдий чинээ тунгалаг байна энэ хэрээр харилцагчийн итгэл үнэмшил бэхжих аж. Тиймээс аль ч орны банкны салбар засаглалдаа гойд анхаарч, түүнийгээ сайжруулж ирсэн байдаг.

“Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал М.Болд “Монгол Улсад өнгөрсөн 22 жилийн хугацаанд 30 банк дампуурсан” гэлээ. Нийгмийн оюун санаанд тод үлдсэн, хэрэг нь хуучраагүй, хамгийн ойрын баримт бол



Фотог Ү.Одбаяр

цагтаа топ явсан “Анод”, “Зоос” банкны дампуурал юм. Тэдний үүсгэсэн шарх одоо ч аниагүй байна. Топ банкуудын азгүйтэл хөрөнгийн зах зээлд итгэх олон нийтийн итгэлийг навс унагаж, банкны салбарт тогтворгүй байдлыг авчирсан гэж хэлж болно.

Банкны засаглал удирдлагын түвшинд доройтож, хэвийн үйл ажиллагаа хямрах шалтгааныг өнөөдөр дээрх хоёр банкны жишээгээр судлаачид тайлбарлаж байна. Хэдий ийм гашуун сургамж байгаа ч Монголын арилжааны банкны салбараас засаглал муутайгаас үүсэх аюул алсраагүй байна. Өнөөдөр, “Транс” банк гэхэд л дотоод засаглал

муудсан, удирдлагын түвшинд үл ойлголцол газар авсан гэх муу нэр зүүж байгаа. Монголбанкнаас тус банкны тусгай эрхийг түдгэлзүүлээгүй ч үйл ажиллагаа нь үндсэндээ зогсонги байдалтай болжээ. Дээр өгүүлсэн топ банкуудын талаарх болсон явдлыг товч эргэн сануулъя.

Үнэт цаасны зах зээлд “Анод” банк 2008 онд хувьцаа гаргасан байдаг. 2010 онд банк санхүүгийн чадваргүй гээд татан буугдсан. Тус банкны хувьцааг худалдан авсан нийт 1245 хүн 9.3 тэрбум төгрөгийн хохирол амссан. “Анод” банкны дампуурал жижиг хувьцаа эзэмшигчдэд гэнэтийн цохилт болсон юм. Тэд саяхныг хүртэл ▶

► Сүхбаатарын талбайд эсэргүүцэл илэрхийлж жагссан ч бодитой үр дүнд хүрч чадаагүй.

“Анод” банкны жижиг хувьцаа эзэмшигчдийн өмгөөлөгч, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн Г.Баяржаргал “Нэг ч хүний хохирлыг барагдуулаагүй. Тиймээс бид үргэлжлүүлэн тэмцэнэ. 100 мянган төгрөгөөс эхлээд хэдэн арван сая төгрөг хүртэлх төгрөгөөр хувьцаа авсан иргэд хохирох учиргүй” гэв.

Монголын арилжааны банкуудаас үйл ажиллагаагаараа эхний тавд багтдаг байсан “Анод” банкны дампуурсан шалтгааныг хэд хэдэн хүчин зүйлтэй холбон тайлбарладаг. Нэг, банкны удирдлагын засаглалын зохистой харьцаа алдагдсан. Хоёр, чанаргүй зээлийн хэмжээ банкны нийт хөрөнгөнөөс давсан. Гурав, хуурамч хувьцаа гаргасан. Дөрөв, Монголбанкнаас тавих шалгуур үзүүлэлтийг хангаагүй.

Зогсолтгүй эргэх хүчний бэлгэдэл болох “Зоос” банк мөн адил 2006 оноос хувьцаагаа арилжаалж эхэлсэн байдаг. Тус банк нийт 636 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хувьцааны 92 хувийг нь нэр бүхий зургаан субъект эзэмшдэг байжээ. “Зоос” банкны өөрийн хөрөнгийн алдагдал нь 41.3 тэрбум төгрөгт хүрсэн нь дампууралд хөтөлсөн гэдэг. Тус банкны нийт хөрөнгө 187 тэрбум, нийт өр төлбөр 195.3 тэрбум төгрөг, алдагдлын хэмжээ 41.3 тэрбум төгрөг болж, нийт зээлийн 33.4 хувь нь чанаргүй гэсэн ангилалд багтсан тул зогсолт хийжээ.

Ийнхүү томоохон банкууд бүдэрсэн нь хөрөнгийн зах зээлийг хөгжлийн хойш татсан. Зөвхөн хөрөнгийн зах зээлд сэв үлдээгээд зогсохгүй эдийн засагт дарамт үүсгэсэн юм. Энэ байдал нь Монголын банкны салбарт компанийн сайн засаглал ямар түвшинд хэрэгжиж байгааг хангалттай харуулсан гашуун сургамж үйл явдал болсон. Тиймээс Монголбанкны ерөнхийлөгч асан Л.Пүрэвдорж “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын “банкны зохистой удирдлага” гэсэн үгийг “банкны зохистой засаглал” гэж 2010 онд өөрчилсөн байдаг.

Цагийн цагт саар жишээ болох “Анод”, “Зоос” банк хөрөнгийн зах

зээлд арилжааны банкууд хувьцаагаа гаргаж худалдах ойрын төлөвлөгөөг эвдсэн юм. Тиймээс Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк арилжааны банкуудыг хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргах эрх үүргийг түр хойшлуулсан. Тэд ч эмээсэн. Цаг үе, зах зээл ч банкны хувьцааг үл тоох хандлага давамгайлсан. Хэн ч тэдэнд итгэхгүй байх ийм нөхцөл бүрдсэн юм.

Өнгөрсөн сард Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан Компанийн засаглалын үндэсний VI чуулган “Монголын банкуудын үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” зорилго дор нэгдсэн нь учиртай. Тус чуулганы үеэр Монголбанкны тэргүүн дэд захирал Б.Жавхлан “Монгол Улсын эдийн засгийн хөгжилд банкууд нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлсэнээр Монголын банкууд үйл ажиллагааныхаа үр нөлөөг сайжруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, улмаар олон улсын хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломжийг өсгөнө” хэмээн онцлов.

Уг нь компанийн сайн засаглал хэнийг ч орхидоггүй. Тухайн компанийн хамгийн үнэ цэнэтэй хүмүүс жижиг хувьцаа эзэмшигчид байх аж. Онцгой бүрэн эрхт банкны салбарт засаглал хэлбэр талаасаа хөгжиж байгаа ч мөн чанар нь хоосон байгааг чуулганд оролцогчид учирлаж байсан юм. Тухайлбал, компанийн засаглалын дүрэм журмыг биелүүлэх хүсэл сонирхол удирдлагын түвшинд сул хэвээр байгааг “Голомт” банкны жишээгээр тайлбарлаж байлаа. Компанийн засаглал буюу хамтын засаглалыг хөгжүүлэх итгэл үнэмшил тааруу байгаагийн зэрэгцээ удирдлагын соёл алдагдаж байгааг хэлж байсан.

“Голомт” банкны хэвийн үйл ажиллагаанд ноцтой өөрчлөлт гараагүй ч хувь нийлүүлэгч талуудын хооронд үүссэн үл ойлголцол банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн гэсэн дүгнэлт өгч байлаа. “Компанийн засаглалын мөн чанар, үзэл санааг удирдлагын түвшинд ойлгож, хүлээн зөвшөөрсөн эсэхээс хамаарч засаглал цул болно” гэж Компанийн засаглалын үндэсний төвийн гүйцэтгэх захирал Ж.Үнэнбат хэллээ.

Засаглалыг хөгжүүлэх удирдлагын итгэл үнэмшил, ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхээс хамтын засаглал хөгжих үгүй нь ихээхэн хамаардаг байна. Өөрөөр хэлбэл, засаглалыг хөгжүүлэхэд эрүүл хөрс шаардлагатай аж. “Засаглалыг төлөвшүүлэхэд удирдлагын манлайлал туйлаас чухал. Бид мэднэ, би чадна гэсэн ойлголтоор асуудалд хандаж болохгүй. Компанийн засаглалыг өнгөрсөн хугацаанд өчнөөн дүрэм, журмаар зохицуулах гэж оролдож ирсэн. Хамгийн гол нь сайн засаглалыг төлөвшүүлнэ гэсэн итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл тухайн компанийн удирдлага, хувь нийлүүлэгч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад байх учиртай. Хэрэв хүсэл эрмэлзэл байхгүй бол хэчнээн хууль, дүрэм баталсан ч амжилтад хүрэхгүй” гэж М.Болд хэллээ. Түүний удирдаж яваа “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн бүрэлдэхүүнд багтдаг “Хас” банк сайн засаглалаараа Монголын банкуудын жагсаалтад дээгүүр байр эзэлдгийг хэн хүнгүй мэднэ.

Хамтын засаглал хэмээн монгол хэлнээ хөрвүүлсэн компанийн засаглал нь дан ганц компанийн удирдлагаас гадна хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, бусад оролцогч талын хоорондын харилцан хамаарлыг багтаасан өргөн ойлголт аж. Тиймээс зохистой засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлбэл эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт, харилцагчдын итгэлийг нэмэгдүүлж, үр ашигтай хяналтын тогтолцоо, удирдлага, эрх мэдэл, ашиг орлогын зүй зохистой зөв хуваарилалтыг бий болгож банкны үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг хэмээн тодорхойлжээ. Ямар ч банк нь гаднын хямралыг тэсээд өнгөрөх чадамжтай байж болно. Харин дотоод засаглал муудсан тохиолдолд хямралд өртөх эрсдэл нь илүү өндөр байдаг аж.

Топ банкуудын азгүйтэл толгой банкуудад том сургамж болсон ч нөхцөл байдал урьдынхаас дээрдэхгүй байгаа нь юуг өгүүлнэ вэ. Засаглалыг түгээн дэлгэрүүлэх, түүнийг өв тэгш хөгжүүлэх, эцэст нь үр шимийг нь хүртэх банкны эзэд засаглалын итгэл үнэмшлээ дархалж авч чадсан болов уу. Банкны дотоод засаглалд сэв сууна гэдэг нь харилцагчдын сэтгэл хүйт даахын шинж хэмээн зүйрлэсэн байдаг.

БИРЖ

ШИНЭ ТОГЛОГЧИЙН ӨНГӨ

И.ОТГОНЖАРГАЛ

Монголын санхүүгийн зах зээлд нэгэн томоохон тоглогч мэндлээд удаагүй байна. Энэ бол “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК юм. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхээр туршилтын арилжаагаа эхэлсэн тус биржийн үйл ажиллагаа хэр жигдэрч байгаа болон мал аж ахуйн орон гэгддэг Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн бирж ямар ач холбогдолтой талаар сонирхуулъя.

Хөдөө аж ахуйн биржтэй болох асуудал сөхөгдөөд хэдэн төрийн нүүр үзсэн. Хөгжингүй орнуудад хөдөө аж ахуйн бирж хөрөнгийн зах зээлээсээ түрүүлж хөгжсөн, санхүүгийн томоохон тоглогч байдаг. Монголын хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжлөөс 20 гаруй жилийн хойно хөдөө аж ахуйн биржтэй болж байгаа нь энэ. Гэхдээ үүнийг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбат арай өөрөөр тайлбарлаж байна. Тэрбээр “Хөдөө аж ахуйн бирж гэдэг Монголд сонгодог утгаараа одоо л байгуулагдаж байгаа. Гэхдээ хөдөө аж ахуйн бирж байгуулах тухай санаа оноо, сэдэл бараг хөрөнгийн зах зээлтэй зэрэгцээд шахуу 1991, 1992 оны үед гарч байсан. Гэм нь тухайн үед бирж гэдэг сонгодог утгаараа биш, бизнесийн буюу явцуу хүрээнд хөгжих гээд байсан юм” хэмээн тайлбарлав.

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбат нь МУИС-ийг математикч, математикийн багш мэргэжлээр дүүргэсэн, ерээд оны сүүлчээс хөрөнгийн зах зээлд хөл тавьж, энэ чиглэлээр гадаад орнуудад нэг бус удаа мэргэжил дээшлүүлжээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлийн нарийн ширийнийг сайн мэдэх нэгэн аж. Энэ дашрамд хэлэхэд, манай сэтгүүл энэ удаа Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг сонирхуулаад зогсохгүй, тус биржийн ТУЗ-ийн гишүүдийг танилцуулах болно.

Биржийн асуудал руугаа эргэн оръё. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны байр Чингэлтэй дүүргийн VI хороо Дамбын гудамж 60/1 байранд байрладаг. Төв оффис нь Барилгачдын талбайн баруун талд байрлах “Хишиг” төвийн гуравдугаар давхарт төвхнөжээ. Хөдөө аж ахуйн бирж /ХААБ/ байгуулах асуудал үе үеийн Засгийн газар, УИХ-аар удтал яригдсаар 2011 оны зургаадугаар сард Монгол Улсын Их Хурлаас ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг батлан гаргаснаар бирж байгуулах боломж нөхцөл бүрдсэн юм. Өөрөөр хэлбэл,

дээрх хуульд хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэгдсэн зах зээлийг хөгжүүлэхээр заасны дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийг байгуулсан байна.

Шинэ цагт уул уурхайн эрчимтэй хөгжилд шахагдан буй Монголын хөдөө аж ахуйн салбар эх орны хөгжлийн ноён нуруу байж ирсэн, цаашид ч эдийн засгийн голлох байр сууриа хадгалах нь ойлгомжтой учраас монголчуудын хувьд шинэхэн мэндэлсэн санхүүгийн зах зээлийн институт болох тус биржээс хүлээх хүлээлт их ▶▶



Фотог Э.Зоригт

ХААБ-ийн арилжааны танхим. 2013.06.17

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүд



Ж.ЭРДЭНЭБАТ
/“Хөдөө аж ахуйн бирж”
ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал/



Ц. БАЯРМАА
/“Хөдөө аж ахуйн бирж”
ТӨХХК-ийн ТУЗ-ийн дарга



Б.Алтангэрэл
/ТУЗ-ийн гишүүн/



И.Цэрэн-Онолт
/ТУЗ-ийн гишүүн/



М.Батгэрэл
/ТУЗ-ийн гишүүн/

Н.Ганибал
/ТУЗ-ийн гишүүн/

Д.Оюун-Эрдэнэ
/ТУЗ-ийн гишүүн/

Э.Эрдэнэсүрэн
/ТУЗ-ийн гишүүн/

О.Сэр-Од
/ТУЗ-ийн гишүүн/

Л.Баатарчулуун
/ТУЗ-ийн гишүүн/




► юм. Түүнчлэн малаар баян Монголд хөдөө аж ахуйн биржийнлангуу бараа таваарын сонголт өргөнтэй байх нь лавтай.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар бол ХААБ-д арилжаалах барааны жагсаалтыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд батлахаар заажээ. Одоогоор хоёр төрлийн бараа буюу ноолуур, ноос арилжаалж буй. Зургаадугаар сарын 4-ний байдлаар Хөдөө аж ахуйн биржээр 4438 тонн ноолуур арилжаалаад байв. Манай улс 18 сая толгой ямаан сүргээс жилдээ 4500-6000 тонн ноолуур самнадаг. Тэгэхээр хөдөө аж ахуйгаас гардаг нийт ноолуурын 80 гаруй хувь нь Хөдөө аж ахуйн бирж өрхөө татаж, үүдээ нээснээс хойших гурван сар гаруйн хугацаанд худалдаалагдсан гэсэн үг. Биржээр хонины ноосны арилжаа ч хийгдээд эхэлжээ.

Ноолуурын үнийн савлагаа арилжээ

Хөдөө аж ахуйн биржтэй болсноор зах зээлд ямар зэрэг хандлага байна вэ гэсэн асуудал зүй ёсоор тавигдана. Үүнд хариулт хайя. Эхлээд биржид арилжаалсан ноолуурын ханшийн графикт анхаарлаа хандуулаарай. Эндээс харахад, сүүлийн 20-иод жилийн хугацаанд зах зээлийн ямар ч зохицуулалтгүй, голдуу гаднын наймаачид болон тэдний дохио зангаагаар хөдөлдөг дотоодын ченжүүдийн өрсөлдөөний дүнд үнэ нь огцом өсөж, навс унах байдлаар тогтворгүй явж ирсэн ноолуурын ханш харьцангуй тогтворжсон байгаа нь сайн үр дүн юм. Нөгөө талаас малчдын хувьд ноолуурын ханшийг баримжаалах боломжтой болж байгаа нь олзуурхууштай. Манай

ХАА-н Биржийн ноолуурын арилжааны үнийн мэдээ /2013.05 сарын байдлаар/



сэтгүүлийн сурвалжлах баг энэ сарын 4-ний мягмар гаригт Хөдөө аж ахуйн биржид очиход Ж.Эрдэнбат захирал “Нэг кг ноолуур өнөөдөр манайд 64000 төгрөгийн ханштай байна” хэмээн сонирхуулж байсан. Тэгвэл өнгөрсөн жилийн мөн үед нэг кг ноолуур 38000 төгрөгийн ханштай байжээ.

Биржээр арилжаалах барааны тодорхойлолт стандарт нь ч төвөгтэй биш аж. Тухайлбал, манай улсын хувьд ноолуурыг өнгөөр нь дөрөв, микроноор нь дөрөв ангилж нийт 17 стандарт мөрддөг бол биржийн барааны тодорхойлолтоор ноолуурыг өнгөөр нь цагаан, цайвар, бараан, ангилаагүй гэж ангилж, хогт хольц нь 10 хувиас ихгүй байна гэж заажээ. Өөрөөр хэлбэл, малчны хотноос ирсэн ноолуурт биржийн босго тийм ч өндөр даваа ►

► биш гэсэн үг. Хөдөө аж ахуйн биржийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг Монголын 21 аймаг, 330 сум, 1200 баг, 150 гаруй мянган малчин өрх хийж байгаа гэж үзэж болно. Гэхдээ тэд биржийн арилжаанд шууд оролцох боломжгүй юм. Хөдөө аж ахуйн гаралтай, бараа түүхий эдийн биржийн тухай хуулиар ч тийм зохицуулалттай. Харин тус бирж олон оролцогчидтой. Худалдаж байгаа тал нь мэдээж малчид, хоршоод, газар тариалан эрхлэгчид, худалдан авч байгаа нь үйлдвэрүүд болон дотоод, гадаадын экспортлогчид. Тэдний авах, зарах эрэлт нийлүүлэлтийн уулзварт тоглогчид нь мэргэжлийн оролцогчид буюу аймаг орон нутаг хариуцсан брокерийн үйлчилгээ эрхлэгч компаниуд. Тэд Хөдөө аж ахуйн биржийн байнгын гишүүн оролцогч брокерууд юм. Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч, тус биржтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулаад, арилжаанд идэвхтэй оролцож байгаа 25 брокерийн компани бий. Эдгээр тусгай зөвшөөрөлтэй брокерийн компаниуд нь орон нутагт заавал бүтээгдэхүүн хадгалах итгэмжлэгдсэн агуулахтай байх ёстой. Ж.Эрдэнэбат захирлын хэлснээр Орхон, Сэлэнгэ, Дорноговь гурваас бусад аймагт итгэмжлэгдсэн агуулахтай, тусгай зөвшөөрөлтэй брокерийн компаниуд ажиллаж байгаа гэнэ. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны танхим одоогийн байдлаар 32 суудалтай. Биржийн үйл ажиллагаанд оролцох брокерийн тоог цаашид хязгаарлахгүй гэж гүйцэтгэх захирал хэлэв. Учир нь ирэх оноос биржийн арилжааг онлайн хэлбэрт шилжүүлэх аж. Түүнчлэн ХААБ-ын ТУЗ-өөс баталсан журмын дагуу биржид гишүүнээр элсэхэд элсэлтийн хураамж 4.5 сая төгрөг, гишүүнчлэлийн жилийн төлбөр нь 2.0 сая төгрөг юм байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар зэрэгцээ зах зээлийг хориглоогүй. Өөрөөр хэлбэл, биржид ноолуур худалдах, худалдан авах ажиллагаа явагдаж байгаа ч гэсэн зах зээлээс хувь хүн болон үндэсний үйлдвэрийнхэн ноолуур худалдан авах нээлттэй. Харин хуулийн нэгэн чухал заалт нь экспортын зориулалттай ноолуурыг заавал биржээр арилжаална гэсэн зохицуулалттай. Тиймээс өнөөдрийн байдлаар биржид арилжаад байгаа 4438 тонн ноолуур нь зуун хувь экспортын зориулалттай юм. Захиалгаас харахад, биржээр арилжаалсан ноолуур Англи, Итали, Япон, Хятад гэсэн дөрвөн орон руу ихэвчлэн гарахаар байгаа аж. Эдгээр зах зээл нь өөр өөр стандарт шаардлага тавьдаг байна. Тухайлбал, Хятад улс гэхэд зөвхөн угаасан ноолуур авах бол Англи, Итали, Япон зэрэг орон самнасан ноолуур авах жишээтэй.

Манайх жилдээ нийт ноолуурынхаа 20-иод хувийг дотооддоо авч, үлдсэнийг нь экспортолдог. Гэхдээ экспортын ноолуурын хэдэн хувьд нь ямархуу боловсруулалт хийж, хаашаа гаргаж байгаа нь тийм ч тодорхой биш байж ирсэн. Харин биржтэй болсноор эмх цэгц, зохицуулалт муутай байсан зах зээлийн бараа бүтээгдэхүүн бүртгэлтэй болж байгаагаараа ач холбогдолтой хэрэг. Түүнчлэн зах зээл ийнхүү эмх цэгцэнд орох нь үйлдвэржилтийн эрин үе гэж яригдаж байгаа өнөө үед дотоодод үйлдвэр байгуулахтай холбоотой төлөвлөлт хийхэд ч тустай гэдгийг Хөдөө аж ахуйн биржийн захирал онцлон тэмдэглэсэн.

Хөдөө аж ахуйн биржид амьд мал арилжаална

Хөдөө аж ахуйн биржид цаашид олон бараа бүтээгдэхүүн худалдаалах байх гэсэн иргэдийн хүлээлт бий байх. Тэгвэл Ж.Эрдэнэбат захирал “Таваарын биржийн хөгжлийн чиг хандлага бэлэн барааны арилжаа гэхээсээ илүүтэй гэрээний арилжаа хөгжиж байгаа. Жишээ нь, Чикагогийн таваарын биржийн арилжаалж байгаа бүтээгдэхүүнийг үнийн дүнгээр нь аваад үзэх юм бол хоёр хувь нь бэлэн барааны таваарын, 98 хувь нь гэрээний арилжаа байх жишээтэй. Бизнесийнхэн урьдчилж түүхий эдээ авах, татах гэдэг утгаараа гэрээний арилжаа чухал. Бидний зорилго бас энэ зүгт явах ёстой. Манай биржид бэлэн барааны арилжаа тогтмолжоод ирэхээр төслийн II шат хэрэгжиж, дераватив буюу үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжаалах юм” хэмээв.

Гэхдээ тус биржийнхэнд амьд мал арилжаалах төлөвлөгөө бий. Энэ талаараа биржээр арилжаалах барааны жагсаалтыг баталдаг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдтай зөвлөх учиртай. Мөн ноолуурын арилжааг жилийн турш явуулахын тулд гурав, зургаа, ес, арванхоёрдугаар сард самнасан ноолуурын фьючерс арилжаалах юм байна. Ингэснээр гурван сарын дараа, хагас жилийн дараа ноолуурын үнэ ямар байх, үйлдвэрүүд аль үед нь түүхий эдээ авах вэ гэх байдлаар төлөвлөх бололцоог олгож өгч байгаагаараа онцлог.

Хөдөө аж ахуйн бирж 35 хүний орон тоотой, долоон албатай. 2013 оны улсын төсөвт хөдөө аж ахуйн бирж байгуулах, тус биржийн агуулах барихад зориулаад 5.0 тэрбум төгрөг суулгасан ч энэ нь одоо болтол биржийн данс руу ороогүй байгаа аж. Ж.Эрдэнэбат “Бид үйл ажиллагааны шимтгэл, хураамж болон өөрийн орлогоороо ажилчдын цалин, байрны түрээс, урсгал зардлаа зохицуулаад явж байна” гэв. Түүнээс шинээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хувьд ямар хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд байна вэ хэмээн асуухад “Хүндрэлтэй асуудал мэдээж байлгүй яах вэ. Гэхдээ зовлон тоочмооргүй байна. Залуучууд дуртай, сонирхолтой ажил мэргэжлээрээ хийе гээд зүтгэхэд болохгүй зүйлгүй. Үл ойлголцлоос болоод тодорхой хэмжээний асуудлууд гарч байгаа. Энэ бол зах зээлээ ойлгоод, биенээ хүндэтгээд явахад шийдэгдчих зүйл, нэг их хүндрэлтэй асуудал биш” хэмээн өгүүллээ.

Эцэст нь хэлэхэд, Монголын санхүүгийн захын шинэ тоглогчийн гарааны өнгө ийм байна. Хөдөө аж ахуйн биржийн төслийн хоёрдугаар шат ирэх оны сүүлч гэхэд хэрэгжиж дууссан байх ёстой. Бэлтгэл ажлыг одооноос хангаад, судалгаа шинжилгээ, гадаад түнштэй хамтрах асуудлууд яригдаж буй юм. Ерөнхийдөө хөдөө аж ахуйн биржид бэлэн барааны спот, гэрээний гэсэн хоёр арилжаа явагддаг болох нь. Энэ тохиолдолд ХААБ бүрэн утгаараа хэрэгжиж, Монголын санхүүгийн зах зээл дээр томоохон тоглогч-институт бий болох нь дамжиггүй. ■

ЗОЧИН

ӨСӨЛТ ГЭДЭГ ӨӨРӨӨ СОРИЛТ

Б.ЭНХЦЭЦЭГ

Марк Клиффорд нь Хонконгт байршилтай Азийн бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирлаар 2007 оноос хойш томилогдон ажиллаж байна. Тэрбээр сэтгүүлч мэргэжилтэй бөгөөд “South China Morning Post”, “The Standard” тэргүүтэй томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслийн ерөнхий редакторын үүргийг гүйцэтгэж байснаас гадна “Business Week” сэтгүүлийн Ази хариуцсан бүсийн редактораар ажиллаж байсан туршлагатай нэгэн. Марк Клиффорд өнгөрсөн жил Монголд ирээд буцахдаа “Mongolia Builds a New Identity” хэмээх нийтлэл бичсэн байдаг. Түүнийг хоёр дахь удаа Монголд зочлох үеэр нь ярилцсан юм.



Марк Клиффорд “Ази бол өнөөдөр гурав дахь багана. Энэ тивийн хүн ам, өсөлтийг харвал зогсоох хүч гэж бараг үгүй мэт санагдаж байна”.

-Энэ удаад Монголд ямар хэргээр ирсэн бэ?

-Дараа жилийн өдийд Монголд уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Азийн бизнесийн зөвлөл 14 оронд гишүүнтэй бөгөөд бүсийн хэмжээнд жилдээ хоёр удаа уулздаг. Уулзалтаа бид янз бүрийн газарт зохион байгуулдаг. Монголоос бусад оронд гишүүдтэй байсан бол өнгөрсөн жил “MHN” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан манайд нэгдсэн. Үүнтэй холбогдуулан зөвлөлийн зүгээс Монголд уулзалт зохион байгуулж, танай улс дахь нөхцөл байдал, боломжийн талаар хэлэлцэхээр шийдсэн.

-Манай уншигчдад Азийн бизнесийн зөвлөлийг танилцуулахгүй юу?

-Албан ёсоор 2002 онд

байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Бидний гол зорилго бизнесийн салбар дахь тэргүүлэгчдийг нэгтгэж, зангиагүй ярилцах. Гишүүдийн хувьд дарга, ерөнхий захирлууд байдаг. Ази тив хүч түрэн гарч ирж буй энэ үед Монгол, Саудын Араб, Япон, Хятад, Энэтхэг тэргүүтэй орны төлөөллийг нэгтгэж, бизнесийнхний хүрээнд бүс нутгийн асуудлаа ойлгох нь чухал.

Өнгөрсөн хугацаанд, хүмүүс хөгжиж буй барууны орнуудад хэт их анхаарал хандуулж ирлээ. АНУ, Их Британи, Евробүсийн орнуудаас илүү их хамаарч байв. Азийн бизнесийнхэн хоорондоо ч тийм их гүн харилцаагүй байлаа. Гэтэл энд л боломжууд байна. Хөршүүдээ сайн таньж, бүсийн хэмжээнд боломж юу байгааг мэдэх хэрэгтэй.

-Хөгжингүй орнуудын эдийн засаг, улс төрийн бодлого хөгжиж буй орнууд тэр дундаа энэ бүс нутаг руу чиглэж байгаатай уялдан зөвлөлийн зорилгод ямар өөрчлөлтүүдийг хийх шаардлага гарч байгаа вэ?

-Үүнийг нөгөө талаас нь харвал Ази бол хөгжингүй дэлхийн нэг хэсэг. Өнөөдөр гурав дахь багана. Би энэ тивд 26 жилийн өмнө буюу 1987 онд нүүж ирж байлаа. Тэр үед Япон тун амжилттай явж байсан ч Азийн үлдсэн хэсэг тийм байсангүй. Хятадын эдийн засаг Өмнөд Солонгосынхоос ч жижиг байв. Тухайн үеийн Солонгосын эдийн засаг тийм ч том байгаагүй. Азийн хөгжлийн хөдөлгүүр нэгэнтээ ассан. Одоо бол азиуд тэрхүү өсөлтийн хөдөлгүүрийнхээ хүчийг хэрхэн нэмж, хурдасгах вэ гэдгээ хамтдаа бодож ▶

► шийдэх хэрэгтэй.

-Азийн бизнесийн зөвлөл байгуулагдсанаас хойш гарсан голлох хөгжлийн өөрчлөлтүүдийг нэрлэхгүй юү?

-Тивийн хэмжээнд илүү хүчирхэгжиж буй нь Азид анхаарлаа хандуулдаг гишүүдийг татахад бидний хувьд илүү амар болсон. Энэ л гол нь гэж бодож байна.

Бидний зүгээс Азийн гишүүнчлэлдээ Ойрхи Дорнодыг хамруулахаар шийдвэрлэсэн. Бүс нутгийн эргэн тойрноос гишүүд хүлээж авах болсон ч 80 хувь нь Азийнх байх ёстой. Бид өмнө нь Саудын Араб, Кувейтийг хамарддаггүй байсан ч одоо бол тийм. Хоёр жилийн өмнө Саудын Арабд уулзалт хийсэн. Тус улсаас манайд хоёр гишүүн байдаг бол Кувейтийн нэг гишүүн саяхан бидэнтэй нэгдээд байна. Энэ талаас нь харвал өөрчлөлт үнэхээр гарсан. Зөвхөн Зүүн Ази, Энэтхэг гэлтгүй Ази тэр чигээрээ нэг утсаар хоорондоо уягдаад байна. Өмнө нь бид Зүүн болоод Өмнөд Ази руу харцаа чиглүүлдэг байсан. Монгол, Афганистан тэргүүтэй улсууд манай байгууллагын дүрэм журмын үүднээс Азид тооцогддоггүй байлаа. Мөн асуудлыг Хонконгийн Засгийн газартай харилцан тохиролцох хэрэгтэй байдаг. Улмаар бид байгууллагынхаа дүрэмд өөрчлөлт оруулж, Монгол Орос тэргүүтэй Төв Азийн, Ойрхи Дорнодын орнуудыг хамрах болсон. Өөрөөр хэлбэл, илүү өргөн цар хүрээнд энэ тивийг харах болсон.

-Ямар шинэ сорилт, боломжууд өнөөдөр гарч ирж байна вэ?

-Бизнесийнхний хувьд гарч ирж буй асар олон боломжийн дундаас тохирохоо сонгох нь шинэ сорилт болж байна. Барууны орнууд тэр дундаа Европт ажилгүйдлийн түвшин өндөр байгаа. Бизнесээ авч үлдэх, ажил олох нь тэдний хувьд томоохон сорилт байгаа бол Азид боломжууд дундаас хамгийн тохиромжтойг нь сонгох, шилдэг боловсон хүчин олох нь сорилт болж байна.

Өсөлт гэдэг өөрөө сорилт. Боломж өсөлтийг удирдах нь сорилт. Хэрэв Монголын эдийн засаг шиг ес эсвэл 19 хувийн өсөлттэй яваа бол хэрхэн

энэ өсөлтийг дааж явах хүмүүсээ олох вэ.

Хүн хэмээх баялаг, авьяас чадварыг олно гэдэг миний бодлоор хамгийн том сорилт. Аливаа байгууллагын хувьд гайхам боломж, тохирох хүнээ сонгон, эрх мэдэл өгч, түүгээрээ дамжуулан ихийг олж авахад анхаарах нь зүйтэй. Энэ бол сонирхол татам сорилтын зэрэгцээ хаана ч олдод байдаг зүйл биш юм шүү.

-Азийн хувьд энэ хамгийн том сорилт уу?

-Хамгийн том сорилтуудын нэг нь яах аргагүй мөн. Магадгүй хамгийн хамгийн нь ч байж мэднэ. Байгаль орчны асуудал үүнтэй зэрэгцэх хэмжээний том сорилт гэж хэлмээр байна.

-Дараагийн 100 жил Азийнх байх эсэхийг өнөөдөр ямар хүчин зүйлс тодорхойлж байна вэ?

-Гайхалтай асуулт байна. Ази дэлхийг захирах эсэхийг мэдэхгүй юм. Гэвч энэ тивийн хүн ам, өсөлтийг харвал зогсоох хүч гэж бараг үгүй мэт санагдаж байна.

Дэлхий ертөнц ирээдүйд илүү олон эсрэг, тэсрэгээс бүрдэнэ. Нэг улс дахин дэлхийг удирдана гэж бодохгүй байна. Гэвч азиудын хувьд боломж хязгааргүй байх нь илэрхий байна. Олон зууны турш хүмүүс хүүхдүүдээ тэр дундаа охидоо сургуульд сургах боломжгүй, эмнэлэгт үзүүлэх мөнгөгүй байлаа. Хүмүүст дутагдах зүйлгүй сайхан амьдрах боломжийг нь тавьж өгөх л хөгжил, өөрчлөлтийн утга учир. Сайхан машин, тансаг сууцтай болох тухай асуудал биш. Эцсийн дүндээ хүмүүсийн л тухай юм. Энэ талаас нь харвал Азийн зуун гэж хэлж болно.

-Монгол дахь хөрөнгө оруулалт, бизнесийн өнөөгийн орчинг та юу гэж бодож байна вэ?

-Бизнесийнхэн тодорхой байдалд дуртай. Ирээдүйд юу болохыг тодорхой мэдэж байхыг тэд хүсдэг. А эсвэл Б гэсэн салаа замын сонголтыг таамаглаж болох ч А,В,С,Д гэсэн сонголттой байхыг тэд хүсэхгүй. Аль замаар явахаа мэдэх газрын зурагтай байх хэрэгтэй гэсэн үг.

-Та Монголд 2012 онд ирснийхээ дараа бичсэн нийтлэлдээ

Монголын эзэнт гүрэн дэлхийг дайлаар мордож, олон улсын тавцанд нэрээ тамгалсан тэр үеийг дурьдсан байсан. Монгол олон улсын тавцанд дахин тодрох боломж олдож буй энэ үед хэрхэн зөв хөдлөх вэ ?

-Дараагийн таван жилд эрчим хүчний ханган нийлүүлэгч болох нь нэн чухал гэж бодож байна. Оюутолгой болон бусад төслөө хэрэгжүүлэх нь олон улсад танигдаж, хөрөнгө оруулагчдыг татахын зэрэгцээ монголд хүлээлгэх тэдний итгэл ч батжина. Азийн дийлэнх улсад байдаггүй газар нутаг, байгалийн баялаг Монголд бий нь гайхалтай.

Өнөөдөр хүн бүр эрчим хүчинд хэт анхаарч байна. Шинэ Зеландыг аваад үзье. Дэндүү жижиг орон атлаа ногоон, цэвэр Шинэ Зеланд гэсэн брэндийг бий болгочихсон байна. Тэнд байгаль орчны эко туршлагыг аялал жуулчлалтай хослуулсан байдаг. Зүүн Ази тэр дундаа 1.3 тэрбум хүнтэй Хятад улсын зүүн хэсэг хамгийн их хүн ам төвлөрсөн хэсэг. Тиймээс тэд Канад, АНУ, Шинэ Зеланд гэсэн цэвэр агаарт загасчилж, морь унаж болох газрыг зорьдог. Монголд энэ бүгд байна.

Ирэх 25 жилд эрчим хүч цойлно гэж хэлмээр байна. Эрчим хүчний гайхалтай суурийг бүрдүүлсэн Катар, Саудын Араб шиг боломжоо сайн харж, ухаалаг ашиглах хэрэгтэй. Ирээдүйдээ хөрөнгө оруулах нь чухал.

Том газар нутаг дээрх цөөн хүн ам, дэд бүтцээ шийдэхэд бэрх гэх мэт сул тал Монголд цөөнгүй ч түүнийг давуу тал болгох боломж бий. Учир нь танай улсад Азийн ямар ч оронд заяагаагүй олон төрлийн байгалийн баялаг байна.

Уул тал, гол нуур, говь цөл гээд итгэмээргүй уудам нутаг байна. Ази хөгжих тусам, энэ тивийнхэн гадагш гарах нь ихсэж, дэлгүүр хэсэхээс илүүг хүсэх болсон. Бусдад байхгүй энэ сайхан орон байхад том дэлгүүрүүд байхгүйдээ санаа зовох хэрэггүй.

Энэ бол ирэх 10 жилийн асуудал. Аялал жуулчлалын боловсронгуй дэд бүтцийг бий болгох нь энэ салбарын хөгжилд төдийгүй монголчуудад нэн ►►

▸ чухал хэрэгцээтэй байна. Ажлын байр бий болно гэсэн үг. Хэрвээ миний өмнө 25 жилийн төлөвлөгөө байсан бол ирэх жилүүдэд эрчим хүчний салбараа зөв хөгжүүлж, хөршүүдтэйгээ эвтэй харилцах тал дээр гол анхаарлаа төвлөрүүлж ажил гэж хэлнэ. Хоёр их гүрэнтэй зэрэгцэн оршдог бодит байдал. Тиймээс тэдэнтэй хэрхэн зохицож оршин тогтнохыг сурахаас өөр аргагүй.

-Хэвлэл мэдээллийн салбарт олон жил ажилласны дараа чухам яагаад Азийн бизнесийн зөвлөлийг сонгосон юм бэ?

-Хэвлэл мэдээллийн салбарт би ихэнхдээ бизнес, санхүү, эдийн засгийн сэтгүүл зүйгээр замнасан. Миний хувьд "Business week", "Eastern Economic Review" тэргүүтэй мэдээллийн хэрэгслүүдэд ажиллаж байсан туршлага бий. Тиймээс Азийн бизнесийн зөвлөлийн ихэнх хүмүүс миний өмнө нь уулзаж, ярилцлага авч байсан хүмүүс байдаг. Ази тив миний хувьд хамгийн сэтгэл татам газар. Хэдийгээр Засгийн газруудын үүрэг их ч хувийн хэвшлийнхэн л энэ өөрчлөлийг бий болгож байгаа. Манай зөвлөлийн гишүүд таван их наяд гаруй ам.долларын зах зээлийн үнэлгээтэй компаниудыг захирч, шууд байдлаар хоёр сая хүн ажиллуулдаг бол шууд

Ирэх 25 жилд эрчим хүч цойлно гэж хэлмээр байна.

бусаар түүнээс ч илүү олон. Тиймээс бизнесийн салбар дахь шийдвэр гаргагчдыг нэгтгэн ажиллах нь илүү өндөр бүтээмжийг бий болгох гайхалтай боломж юм.

-Азидаа аль улсыг тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг Та шилдэг нь гэж үнэлдэг вэ?

-Өөрийн дуртай нэг мэдээллийн хэрэгслээ сонгоод хэл гэх нь хүүхдүүдийнхээ дундаас хамгийн хайртайг нь сонго гэж байгаатай адил санагдаж байна. Илүү чөлөөт мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн урсгалтай орнуудын нийгэм дэх нөлөөлөл нь харьцангуй эерэгээр тусч байдаг. Бизнес, улс төрд ч адилхан. Улс бүр өөр учраас тодорхой хэлэхэд хэцүү юм.

-Хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ямар нийтлэг сорилттой тулгарч байна вэ?

-Хэвлэл мэдээлэл гэдэг олон нийтэд хүрдэг үйлчилгээ учраас тэдний асуудал ч ерөнхийдөө адилхан. Бүх л байгууллага зарлагаа нөхөж, ажилчдынхаа цалинг өгөх ёстой. Гэхдээ эдийн засаг хөгжих тусам асуудлаа шийдэх өргөн боломж олддог. Сурталчилгаа өгдөг нэг нь уурлалаа гэхэд бусад нь байгааг санах хэрэгтэй.

Эсвэл захиалагчид байна шүү дээ. Энэ бол үйл ажиллагааны хувьд бэрх хувилбар. Томоохон улс төрч, бизнесийнхний дэмжлэггүйгээр төрөлжсөн санхүүжилтээр үйл ажиллагаагаа хангалттай хэмжээнд явуулна гэдэг хэцүү. Түүхийг сөхвөл, Азийн олон оронд шоронд орсон ч хамаагүй хэмээн боддог хүмүүсийн эрхлэн гаргадаг цөөн хэвлэл байсаар ирсэн. Гэхдээ би дийлэнх нь бусдын эрхшээлд байдаг гэж хэлээгүй шүү. Эрсдэлийг үүрэхэд үргэлж бэлэн байдаг баатарлаг хэсэг бүлэг хүний тухай ярьж байгаа юм. Энэ нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүсэх нөхцөл, зарим үед халхавч болох нь бий. Улмаар илүү хүчирхэгжиж, бусдаас үл хамаарах үзэл санаа газар авахад нөлөөлдөг. Гэвч хөгжингүй орнуудад хүртэл энэ асуудал байсаар ирсэн. Ялангуяа дарамт, шахалт энэ салбарт хүчтэй ноёрхсоор байна.

Хувийн хэвшил, төр засгийнхан хэвлэл мэдээллийн чөлөөт байдал, хүмүүсийн юу бичихийг зааж болохгүй гэдгийг ойлгох нь нэн чухал. Гэвч энэ бол хэзээ ч дуусдаггүй тэмцэл.

-Та энэ удаагийн айлчлалынхаа дараа Монголын тухай дахин нийтлэл бичих үү? Тийм бол ямар өнцгөөс нь хөндөх вэ?

-Би энд байх хугацаанд сонирхолтой олон уулзалтыг хийж яваа. Хөгжиж буйг харах сэтгэл хөдлөм байна. Сонгууль, Оюутолгойн анхны тээвэрлэлт зэрэг сонирхолтой олон үйл явдал та бүхнийг хүлээж буй. Энэ бүхний дараагаас улс орны байдал харьцангуй тогтуун болж ирэх болов уу гэж найдаж байна. Тодорхой байдал бол бизнесийнхний хамгийн их хүсдэг зүйл. Юу болохыг харж л байя. Одоогийн байдлаар би нийтлэл гэхээсээ Азийн компаниудын байгаль орчны тал дээр гаргаж буй санаачилгын талаар бичиж буй номондоо илүү анхаарч ажиллаж байгаа. Ном маань дараа жил хэвлэгдэнэ.


-Таны бичиж буй номын агуулгатай холбогдуулаад асуухад энэ тал дээр Монголын нөхцөлийг Та хэрхэн дүгнэж байна вэ?

-Монгол Улс эрчим хүч тэр дундаа цахилгааны дутагдалд ороод байгаа. Мөн нүүрснээс хэт хамаарал бүхий эрчим хүчний хэрэглээтэй. Гэвч нар, салхины асар их баялгаа ашиглан эрчим хүчний нийлүүлтээ нэмэгдүүлэх "лут" боломж байна. Үүний зэрэгцээ бүтээмж өндөртэй барилгын материал ашиглаж болно. Ийм материалаар барьсан барилгуудтай болвол, халааж, хөргөхөд эрчим хүч бага зарцуулна гэсэн үг. Тохь тухтай сайхан амьдрал цогцлоох нь хүмүүсийн хувьд эрхэм зорилго. Түүнээс нүүрс, салхи болон нар эсвэл ямар барилгын материалаар барьсан нь сонин биш байдаг. Асуудлыг шийдвэрлэх асар их боломж бий. ■



ИЛЧБЭЭНД

**АЯЛАЛ ЗУГААЛГА
АМРАЛТ ЗУСЛАН
АХУЙН БҮХ
ХЭРЭГЦЭЭНД**



**5 ЛИТРИЙН
БАГТААМЖТАЙ
18-20 ЦАГ
ТАСРАЛТГҮЙ АСАХ
ХҮЧИН ЧАДАЛТАЙ**

**ДАХИН ДАХИН
ЦЭНЭГЛЭЖ АШИГЛАХ
ЗОРИУЛАЛТТАЙ**



**ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР
АЮУЛГҮЙ
АВСААРХАН**



**МОНГОЛД АНХ УДАА
"ИХ ХАРАНГА" КОМПАНИЙ
ЗАХИАЛГААР ТҮРК УЛСАД
ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
"ИЛЧГАЗ"**

**"ГОРГАЗ"
КОМПАНИЙ
БОРЛУУЛАЛТЫН 7-Н
ЦЭГЭЭС ХУДАЛДАН АВААРАЙ**



ЕВРОП ЧАНАРЫН БАТАЛГА

УТАС: 91116587,

Вэб хаяг:
www.ikharanga.mn

Утас:

(976)-7010-0156
9111-6587, 9666-7068

Факс:


(976)-11-680437

И-мэйл:

ilchgaz@kharanga.mn

Хаяг:

ИХ ХАРАНГА ХХК оффис
Энхтайвны өргөн чөлөө 18/1
Баянгол дүүрэг 5-р хороо
Монгол улс, Улаанбаатар хот



Бууруулах боломж

Эдийн засагт мөнгөний олдоц нэмэгдэж, эрсдэлийн хэмжээ буурч, инфляцийн хүлээлтийг нам дор байлгавал зээлийн хүү буурах боломжтой. Өнөөгийн нөхцөл байдалд Монголд ямар арга замаар хүүгийн түвшинг бодитойгоор бууруулж болох вэ?

Мөнгөний олдоц

- Банкнаас гадуур өөр санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх. Аливаа компанийн хувьд хөрөнгө оруулалт болон зээл гэсэн санхүүжилтийн хоёр эх үүсвэрийг хослуулан хэрэглэдэг. Банкнаас зээл авч санхүүждэг нь давамгайлсан байдаг тул зээлийн хүү өндөр тогтоод байгаа. Тиймээс хөрөнгө оруулалт хийдэг бүтцийг хөгжүүлэхэд түлхүү анхаарах хэрэгтэй болж буй. Тухайлбал, үүнд даатгалын компаниуд хөрөнгө оруулалт хийх боломжийг нээх, хөрөнгө оруулалтын сангуудыг үйл ажиллагааг хууль, бодлогын замаар дэмжих, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Зээлийн эх үүсвэрийн жишээ

	Зээлийн хүү	Зээлийн хэмжээ	Зээлийн хугацаа
ББСБ	42%	154 тэрбум	0.3 жил
Арилжааны банк	18.7%	6800 тэрбум	1.5 жил
Гадны хөгжлийн банк	5%	594 тэрбум	5 жил
Төслийн зээл	8%	550 тэрбум	5.5 жил
Гадны арилжааны банкууд	5%	351 тэрбум	2 жил

- Урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх. Хөгжлийн банкны бонд болон “Чингис” бонд олон улсын зах зээл дээрээс 3-5 жилийн хугацаатай хөрөнгө босгосон. Үүнээс өмнө Монгол урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэр ховор байсан тул тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж хүү өндөр байлаа. Цаашид хөрөнгө оруулалт татах, бонд болон хувьцаа гаргах замаар урт

хугацааны эх үүсвэрийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх хэрэгтэй.

- Монголын эдийн засгийн суурь үзүүлэлтийг сайжруулж, хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байлгах. Макро түвшинд, Fitch, Moody's гэх мэт агентлагууд нь улс орны зээлжих зэрэглэл тогтоодог. Энэ зэрэглэл нь тухайн улсын эрсдэлийг илэрхийлэх бөгөөд улсын зээлжих зэрэглэлийг сайжруулбал зээлийн хүү буурах боломжтой. Нөгөөтэйгүүр зэрэглэлийг нэг шат ахиулж чадвал “хөрөнгө оруулалтын” ангилалд Монголд орж ирэх мөнгөн дүн огцом нэмэгдэх, нөгөө талаас хүүгийн түвшин ойролцоогоор 2-3 хувиар шууд буурах боломжтой. Өөрөөр хэлбэл, гадаадын санхүүгийн байгууллага, тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сангуудын бодлогод зээлжих зэрэглэлийн заалт, мөн нэг улсад хуваарилах хязгаарлалтууд орсон байдаг. Хэрэв Монгол Улс өөрийн зэрэглэлээ сайжруулж чадвал дээрх сангуудаас автоматаар хуваарилалт хийгдэх боломжтой болно гэсэн үг.

Инфляци, инфляцийн хүлээлт



- Мөнгө хадгалах эсхүл зарцуулах сонирхолд нөлөөлж байдаг учир инфляци болон хүлээгдэж буй инфляцийн түвшинг нам дор байлгах хэрэгтэй. Цалин, мөнгө нэмэх талаар олон нийтэд зарлах, үндэслэлгүй нийтээр нь цалин нэмэх, хавтгайрсан бэлэн мөнгө тараах зэрэг нь инфляцийн хүлээлтэд шууд нөлөөлдөг. Үүнийг төр засгаас явуулж байгаа бодлогодоо анхаарах нь зүйтэй.

Эрсдэл

- Эрсдэлийн үнэлгээнд зээлдэгч эрсдэлийн үнэлгээ шингэсэн гэж ойлгож болно. Нэгэнт эрсдэлийг бууруулах нь компанийн зээлийн хүү буюу санхүүжилтийн зардлыг шууд багасгадаг тул хөгжингүй орнуудын санхүүгийн зах зээлд эрсдэлийг бууруулах санхүүгийн бүтээгдэхүүнүүд түгээмэл дэлгэрсэн байдаг. Үүнд баталгаа гаргах, ирээдүйн орлогыг барьцаалах, валютын ханшийн хамгаалалт хийх, даатгал хийлгэх гэх мэт санхүүгийн олон хэрэгслийг дурьдаж болно. Эдгээр нь олон улсын гэрээ хэлцэлд хэрэглэгдэх нь олонтаа байдаг. Жишээ нь, улс төрийн байдал тогтворгүй байдаг Африкийн орнуудын улс төрийн эрсдэлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүнийг томоохон даатгалын компаниуд нэвтрүүлсэн бөгөөд үүнийг худалдаж авснаар компаниуд их хэмжээний эрсдэлийг хааж хүүгийн зардлыг бууруулах боломжтой.

- Үүний адил бизнес болон хөрөнгө оруулалтын төслийн шат бүр дээр эрсдэлийг аль болох бага байлгах нь чухал. Тухайлбар зам барих том төсөл байлаа гэхэд удаах хуудсан дахь зурагт харуулсан олон талын харилцаа байгаа. Харилцаа тус бүр дээр гэрээнүүдийг сайн байгуулах нь гүйцэтгэл, ашиглалтын явцад гарах эрсдэлийг бууруулах тул санхүүжилтийн зардал доошлох нөхцөл бүрдэнэ. ➤

Зам барилгын төсөл



• Нөгөө талаас зээлдүүлэгчийн буюу арилжааны банкны үйл ажиллагааны үр ашигтай байдал давхар нөлөөлж болно. Үйл ажиллагааны зардал, үр ашиггүй байдал өндөр тусам банкууд илүү өндөр хүүгийн түвшин тогтоох шаардлагатай

болно. Мөн банкны үйл ажиллагаа тогтвортой байх тусам банк өөрөө илүү хямд хөрөнгийн эх үүсвэр төвлөрүүлэх боломжтой. Банкны хүүгийн маржин 2012 оны сүүлээр долоон хувь орчим байгаа харьцангуй өндөр үзүүлэлт юм. ■

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БҮРХЭГ БАЙНА



ЯН ХАНСЭН
(Азийн хөгжлийн банкны Ахлах эдийн засагч)

Дэлхийн санхүүгийн төлөв байдал дэвсгэлийн зургаан сард сайжирч, хөрөнгийн зах зээл идэвхжсэн ч эдийн засгийн сэргэлт сул хэвээр байна. Энэ оны урьдчилсан таамаглалаас харахад оны эхний хагаст өндөр хөгжилтэй орнууд

төсвийн бодлогоо чангатган эдийн засгийн аажуу өсөлтийг бий болгох зарим шинэ болон хөгжиж буй эдийн засагтай улс орнууд өндөр өсөлттэй байх хүлээлт байна. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй эмзэг,

түүхий эдийн үнэ буурч байгаа нь Монгол Улсын эдийн засгийн төлөв тодорхойгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Дэлхийн эдийн засгийн энэхүү урьдчилсан таамаглалыг Азийн хөгжлийн банкнаас дөрөвдүгээр сард ▶

► нийтэлсэн энэ оны Азийн Хөгжлийн төлөв (АХТ) тайланд үндэслэсэн болно.

Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сул байгаа нь дэлхийн эдийн засгийн сэргэлтийг сааруулж байна

Өнгөрсөн жилийн эхний хагаст дэлхийн эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц удааширсаны дараагаар хөгжиж буй орнууд дахь эдийн засгийн үйл ажиллагаа тодорхой түвшинд тогтворжиж, зарим шинэ болон хөгжиж буй эдийн засгийн өсөлт эрчимжсэн байна. Зах зээлийн шинжээчид үүнийг “хоёр хурдтай дэлхийн эдийн засаг” хэмээн нэрлэсэн ба хөгжиж буй орнууд хамгийн өндөр хурдтай эгнээнд, харин хөгжилтэй эдийн засгууд хамгийн нам хурдтай эгнээнд яваа аж.

Улсын өрийн түвшин нь үлэмж өндөр, төсвийн зардлаа танаж буй өндөр хөгжилтэй орнуудад мөнгөний бодлогын стандарт бус шийдлийг нийт эрэлтийг дэмжих зорилгоор нэвтрүүлж байгаагаас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын урсгал илүү эрсдэлтэй хөрөнгө рүү чиглэж байна. Сүүлийн зургаан сарын хугацаанд дэлхийн санхүүгийн зах зээл сайжран, улмаар дэлхийн эдийн засаг сэргэхэд дэмжлэг болж хөрөнгийн зах зээлүүдийг идэвхжүүлээ. Олон улсын хөрөнгийн биржүүд хөдөлгөөнд орж энэ оны эхэн үетэй харьцуулахад “MSCI” дэлхийн индекс 8.4 хувиар өсчээ. АНУ-ын Доу Жонсын Аж үйлдвэрийн дундаж (Dow Jones Industrial Average) болон S&P 500 индекс энэ жилийн дээд түвшиндээ хүрсэн

АХТ болон АХТ-ын нэмэлт, өөрчлөлт нь Ази, номхон далайн 45 орны хөгжиж буй орнуудын өнгөрсөн жилийн эдийн засгийн үзүүлэлтэд цогц дүн шинжилгээ хийж, ирэх хоёр жилийн эдийн засгийн төлөвийг урьдчилан тооцож, танилцуулдаг АХБ-аас жил бүр гаргадаг эдийн засгийн голлох тайлан юм.

бол Токиогийн хөрөнгийн биржийн Топикс 500 (Тоpix 500) индекс оны эхэн үетэй харьцуулахад 26 хувиар өсч, Европын Стокс 600 (Stoxx Europe 600) индекс таван жилийн дээд түвшиндээ хүрсэн байна.

Гэсэн ч улс орнуудын бодлогын хүү урт хугацааны туршид хэт бага байх нь хөрөнгө оруулалтын урсгалын тэнцвэрийг өөрчилж, эрсдэл үүрэх сонирхлыг өдөөснөөр ноцтой сөрөг дагаварт хүргэж болзошгүй байна. Ялангуяа зээлийн эрсдэл дутуу үнэлж, шинээр хөгжиж буй эдийн засгууд руу хөрөнгө оруулалтын урсгал хэт ихээр чиглэвэл аюултай. Өнгөрсөн онд хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт удаашран, 1.2 хувиар өссөн ба Евробүсийн ДНБ 0.6 хувиар буурсан байна.


Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг аажмаар сэргэх төлөвтэй байна

Хэдийгээр тодорхой бус хүчин зүйлс их ч, 2013 оны таамаглалаар оны эхний хагаст хөгжингүй орнууд төсвийн бодлогоо чангаруулах явц үргэлжилж, улмаар эдийн засгийн аажуу сэргэлт эхлэх төлөвтэй

байна. 2013 онд ДНБ-ий өсөлт нэг хувьд хүрч, улмаар 2014 онд 1.9 хувь болно. Өнөөдрийг хүртэл давхар хурдтай сэргэлт хэмээн нэрлэгдэж байсан үйл явц цаашид гурван хурдтай сэргэлт болж хувирахаар байна. Өөрөөр хэлбэл, шинэ болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын өсөлт эрчимжих бол, хөгжингүй орнуудын хувьд хоорондох ялгаа нь улам тодорч нэг талд АНУ, нөгөө талд Евробүсийн эдийн засгийн өсөлт өөр өөр хурдтай болох аж.

АНУ-д хувийн хэвшил хүчирхэг хэвээр байна

АНУ-ын хувьд өнгөрсөн оны сүүлчийн улиралд эдийн засгийн өсөлт удааширсан ч ДНБ-ий жилийн нийт өсөлт 2.2 хувь байсан нь 2011 оны 1.8 хувийн өсөлтөөс өндөр байв. Хэрэглэгчдийн худалдан авалт, үл хөдлөх хөрөнгө болон хөдөлмөрийн зах зээл дээрх өөрчлөлтүүдээс харахад АНУ-ын эдийн засаг аажмаар сэргэж байна. Эдийн засгийн өсөлтөөс ямагт “хоцорч” байдаг ажилгүйдлийг авч үзвэл өнгөрсөн оны есдүгээр сард 2009 оноос хойш анх удаа найман хувиас доошилжээ. Харин ►



► үүнээс хойш төдийлэн буураагүй бөгөөд 2013 оны дөрөвдүгээр сард 7.5 хувьтай байсан нь олон жилийн дундаж болох зургаан хувиас нэлээдгүй өндөр үзүүлэлт юм.

2013 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр “төсвийн ангал”-д унахаас сэргийлэх зорилгоор АНУ-ын шийдвэр гаргагчид төсвийн орлогоо нэмэгдүүлэх зарим шийдлийг хэрэгжүүлэх тохиролцоонд хүрсэн билээ. Гэвч энэ тохиролцоо нь төсвийн зарлагыг танах явцыг ердөө хоёр сараар хойшлуулж чадсан аж. Хууль санаачлагчид төсвийн алдагдлыг бууруулах багц шийдэл дээр нэгдмэл байр суурьт хүрээгүй тул төсвийн зарлагыг нийтээр нь танах хууль 2013 оны гуравдугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болов. Эдийн засгийн байдал тодорхой бус байгаа үед татварын хувь нэмэгдэж, төсвийн зарлага танагдах нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гарцыг бууруулж, хэрэглэгчдийн эрэлтийг багасган эдийн засгийн өсөлтийг богино хугацаанд сааруулах талтай юм. АНУ-ын Конгрессийн дэргэдэх Төсвийн хорооны тооцоогоор 2013 онд төсвийн зарлагыг 85.4 тэрбум ам.доллараар танах бөгөөд энэ төсвийн бодлогын өөрчлөлт нь 2013 оны АНУ-ын эдийн засгийн өсөлтийг 1.5 нэгж хувиар бууруулах аж.

Төсвийн зарцуулалт буурч байгаа нь нөгөө талаасаа хувийн хэвшлийн хөгжлийн эрчээр нөхөгдөх төлөвтэй байна. Иймд 2013 онд АНУ-ын эдийн засаг хоёр хувиар өсөх тооцоотой байгаа нь 2012 оны өсөлтөөс ялимгүй бага юм. Төсвийн чангаруулалтыг аажмаар бууруулах төлөвтэй боловч мөнгөний бодлого тэлэлттэй байх хандлагатай. Харин 2014 онд АНУ-ын ДНБ-ий өсөлт аажмаар эрчимжиж, эдийн засаг 2.6 хувиар тэлэх хүлээлт байна.

Евробүсийн эдийн засаг зургаа дахь улиралдаа агшсаар

Европын Төвбанк 2012 оны долоодугаар сард еврог хамгаалах зорилгоор бонд худалдаж авах

хөтөлбөр хэрэгжүүлэхээ зарлахад Евробүс удахгүй задрах нь гэх түгшүүр намжсан билээ. Улмаар ХБНГУ-ын Засгийн газрын бондын хүү нэлээд буурсан аж. Гэсэн ч, төсвийн таналтын арга хэмжээнээс үүдэн ажилгүйдэл нэмэгдэж, нийгмийн тайван бус байдал даамжран бүсийн орнуудын эдийн засаг агшсан хэвээр байгаа тул евро цаашид оршин тогтнох чадамжтай эсэхэд эргэлзээ үүссээр.

Евробүсийн ДНБ 2012 онд 0.6 хувиар буурсан аж. Хэдийгээр гадаад худалдаа ашигтай гарч ДНБ-ий хэмжээнд эерэг хувь нэмэр оруулсан. Гэвч ажилгүйдлийн түвшин өндөр, хэрэглэгчийн итгэл сул доройгоос улбаалан хувийн хэвшлийн хэрэглээ нэлээд буурч, улмаар ийнхүү ДНБ-д нөлөөлөв. 2013 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеийнхээс нэг хувь, 2012 оны дөрөвдүгээр улирлаас 0.2 хувиар бага гарсан байна. Ийнхүү бүсийн ДНБ-ий хэмжээ 2011 онд эдийн засаг унаж эхэлснээс хойш зургаа дахь улиралдаа буурчээ.

Эдийн засгийн уналт 2013 онд үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд ДНБ-ий бууралт 0.3 хувь байна хэмээн тооцоолж байгаа аж. Евро бүсийн зах хязгаар дахь орнууд бүсийн нийт өсөлтийг хойш чангаасан хэвээр байх бөгөөд энэ нь төсвийн таналт, өрсөлдөөний чадвар дорой, банкны салбарын хөрөнгийн байдал хүнд байгаагаас үүдэлтэй. 2014 онд бүсийн эдийн засаг аажмаар сэргэж 1.2 хувийн өсөлттэй байна хэмээн таамаглажээ.

Японы эдийн засгийн шинэ бодлого

Японы эдийн засаг 2012 онд хоёр хувиар өссөн бөгөөд 2013 оны эхний улиралд өмнөх оны сүүлийн улиралтай харьцуулахад 0.9 хувиар өссөн нь гайхал төрүүлэхүйц байв. Японы шинэ Засгийн газраас олон жилийн туршид дефляцитай эсвэл үл ялиг өсөлттэй байсны эцэст эдийн засгийн шинэ бодлого хэрэгжүүлэхээ зарласан. Энэ


нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, инфляцийг хоёр хувьд барих, төсвийг ДНБ-ий 4.8 хувьтай тэнцүү хэмжээгээр тэлэх зэрэг зарчимд үндэслэх аж. 2012 оны арваннэгдүгээр сарын дунд үеэс хойш иений ам.долларт хөрвөх ханш 23 хувиар суларч, Японы хөрөнгийн биржийн Топикс индекс энэ оны эхний хагаст 26 хувиар өссөн нь хөгжилтэй орнууд дундаа хамгийн өндөр үзүүлэлт байсан. 2013 оны эдийн засгийн өсөлт 1.2 хувь, 2014 онд 1.4 хувьд хүрнэ хэмээн үзэж байна.

Хятадын эдийн засгийн өсөлт энэ оны эхний улиралд дахин буурлаа

Гадаад орчин сөргөөр өөрчлөгдөж, дотоодын үл хөдлөх хөрөнгийн зах зээл хөрснөөс улбаалан БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2011 оны 9.3 хувиас 2012 онд 7.8 хувь болж буурсан нь сүүлийн 13 жилийн хамгийн сул үзүүлэлт боловч тус улсын Засгийн газрын төлөвлөсөн 7.5 хувиас давсан байлаа. Эдийн засгийн өсөлт долоон улирлын туршид буурсны эцэст өмнөх оны IV улиралд эрчимжсэн. Гэвч энэ оны I улиралд дахин саарлаа. 2012 онд нийт хэрэглээний хэмжээ хөрөнгө оруулалтаас илүү байсан нь эдийн засгийн өсөлтөд нэмэр болсон. Худалдааны гол түншүүдийн эрэлт хэрэгцээ сул байснаас экспортын өсөлт 2011 оны 20.3 хувиас 7.9 хувь болтол буурсан бөгөөд импорт 4.4 хувиар өссөн нь 2011 оны 24.9 хувийн үзүүлэлтээс үлэмж багасчээ. БНХАУ-ын хувьд Монгол Улсын экспортын дийлэнхийг (2012 онд 92.6 хувь байсан) шингээж байна.

БНХАУ-ын дотоодын хэрэглээ болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт цаашид эрчимжиж, эдийн засгийн өсөлт 2012 оны 7.8 хувьтай харьцуулахад энэ онд 8.2 хувь хүртэл өсөхөөр байна. Харин 2014 онд найман хувь болно хэмээн АХТ таамаглал дэвшүүлсэн. Зарим шинжээч болон зах зээлийн ►

Өсөлтөд оруулсан хувь нэмэр (эрэлт талын хүчин зүйлс)-Евробүс



оролцогчийн зүгээс өсөлтийн энэхүү таамаглалыг тодорхой хэмжээгээр бууруулж байна. Учир нь БНХАУ-ын эдийн засаг дэлхийн эдийн засгийн сэргэлтээс ихээхэн хамаарах бөгөөд сэргэлт удаашралтай байх төлөв харагдаж байна. Энэхүү нөлөөллийн гол эрсдэл нь БНХАУ-ын худалдааны хамгийн том түнш болох Евробүсийн эдийн засгийн төлөв бүрхэг байгаагаас улбаатай юм.

Евробүсийн хямрал дунд хугацаанд АНУ болон Японы санхүүгийн байдал тодорхой бус байгаа нь дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж байна

Ойрын хугацаанд дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвд сөргөөр нөлөөлөх гол эрсдэл Евробүсээс үүдэлтэй байна. Харин дунд хугацаанд АНУ болон Японы Засгийн газраас төсвийг чангатгах бодлого барих төлөвлөгөөгүй байгаагийн зэрэгцээ АНУ-ын хувийн хэвшлийн өр их, хөгжилтэй орнуудын хувьд эдийн засагтаа түлхэц өгөх шаардлага гарахад орон зай хязгаарлагдмал, евробүсэд институцийн шинэчлэл хангалтгүй байгаа нь эрсдэл

үүсгэж болзошгүй байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч байгаа нь түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж байна. Тус орны хувьд 2013 оны эхний дөрвөн сард зэс болон зэсийн бүтээгдэхүүний импорт 27.2 хувиар буурчээ. Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн олон улсын зэх зээлийн үнэ 2011 оны эхээс хойш буурсан байна. Зэсийн дундаж үнэ дөрөвний нэгээр буурсан бол эрчим хүчний нүүрсний үнэ 34 хувиар унасан аж. Энэ жилийн хувьд зэсийн үнэ өнгөрсөн оны эхний таван сарын байдалтай харьцуулахад долоон хувиар буураад байна. Харин коксжих нүүрсний үнэ сүүлийн гурван жилийн хамгийн доод цэгтээ хүрлээ.

Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв эмзэг, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан зэрэг нь Монгол Улсын эдийн засгийн хувьд тодорхой бус байдлыг даамжруулж байна

Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны ерөнхий төлөв эсрэг байгаа бөгөөд 2013, 2014 онд эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор хэмжигдэх

төлөвтэй байна. Гэсэн хэдий ч Монголын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай бөгөөд мөчлөг дагасан төсвийн бодлогын улмаас олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэлд нэн өртөмтгий байна. 2012 онд уул уурхайн салбар нийт ажиллах хүчний хоёр хувийг ажиллуулж, нийт экспортын 89.2 хувь, төсвийн орлогын 16.7 хувь, ДНБ-ий 18.6 хувийг бүрдүүлжээ. 2011 онд төсвийн алдагдал ДНБ-ий 4.8 хувьтай тэнцсэн бол 2012 онд 7.7 хувь болж нэмэгдсэн байна.

2013-2014 онд уул уурхайн салбар хөгжлийн хөдөлгөөр хэвээр байна. Үүнд энэ сард Оюутолгойн зэс, алтны уурхайн анхны арилжааны бүтээгдэхүүн голлон нөлөөлнө. Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв “бүрхэг” байгаагийн зэрэгцээ БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тодорхой бус, түүхий эдийн үнэ унасан хэвээр байгаа нь Монголын эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулж болзошгүй. 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралд хамгийн ихээр өртсөн орны тоонд Монгол Улс багтаж байсныг санахад илүүдэхгүй юм.

2012 онд Монголын эдийн засгийн өсөлт 2011 оны 17.5 хувьтай харьцуулахад 12.3 хувь болж буурсан бөгөөд 2013 оны эхний улиралд 7.2 хувьд хүрсэн байна. 2013 оны эхний дөрвөн сарын экспортын хэмжээ (тогтмол үнээр) өмнөх оныхоос 5.5 хувиар буурсан бол нүүрс, зэсийн үйлдвэрлэлийн хэмжээ 10.5, 4.5 хувиар тус тус багасчээ. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ огцом унавал Монголын эдийн засаг, төсөв, санхүүгийн байдалд ноцтой нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Иймд Хөгжлийн банкаар дамжих нэгдсэн төсвийн бус зарлага болон төсвийн нийт зарцуулалтыг хязгаарлах, түүхий эдийн үнийн болзошгүй хямралыг даван туулах хуримтлалыг бий болгох нь Монгол Улсын эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэл болно. ■

ХЭТЭВЧ

ХҮНСЭЭ ЦУГЛУУЛЪЯ

Г.ОРХОН

Монголчуудын хүнсний гол хэрэглээ болох мах, гурил тэргүүтэй хүнсний бүтээгдэхүүний үнэ ханш байнгын савлагаатай байдагт иргэд бухимдсаар ирсэн. Энэ үүднээс нийслэлчүүдийн хүнсээ базаадаг гол төвүүдэд дээрх бүтээгдэхүүний үнийн мэдээллийг хүргэж байна.

ҮСХ-ны судалгаанд савласан дээд гурилын үнэ өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 1.7 хувиар буурч, задгай I зэргийн гурилын үнэ 1.0 хувиар өссөн тухай дурджээ. Харин доорх захуудад:

Гурилын үнэ /кг, төгрөгөөр/


	Төрөл	"Барс" хүнсний зах	"Бөмбөгөр" худалдааны төв	"Хүчит Шонхор" хүнсний зах
Улаанбаатар	/дээд 25 кг/	22000	22000	20000
	/I 25 кг/	14500	14500	15300
	/II 25 кг/	9000	10000	9500
Хурх	/дээд 25 кг/	23000	-	
	/I 25 кг/	15500	15500	
	/II 25 кг/	9000	-	
Цесна	/дээд 25 кг/	33000		29500
Алейка	/дээд 25 кг/	25000-26000	27000	24000



"Бөмбөгөр" худалдааны төвд энэ сарын 14-нд Улаанбаатар гурилын нийлүүлэлт зогссон тухай тус захын худалдагчид яриу.

Хүнсний ногоо /кг, төгрөгөөр/

	"Барс" хүнсний зах	"Бөмбөгөр" худалдааны төв	"Хүчит Шонхор" хүнсний зах
Монгол төмс	700	700	500
Лууван	1200	1500	1500
Манжин	1500	2000	1400
Хятад байцаа	1200	1500	1100
Сонгино	1000-1200	1500	1300-1500
Сармис	3000	4500	3000



Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-ны судалгааны сүүлийн тайлангаас /2012.06.12/ үзэхэд үхрийн ястай махны үнэ өмнөх сарынхаас 0.3 хувиар, адууны махны үнэ 1.6 хувиар өссөн бол үхрийн цул махны үнэ 0.3 хувиар, ямааны махны үнэ 2.1 хувиар буурчээ.

Махны үнэ /кг, төгрөгөөр/

	Төрөл	“Барс” хүнсний зах	“Бөмбөгөр” худалдааны төв	“Хүчит Шонхор” хүнсний зах
Хонины мах	Ястай	8500	8500	7800
	Цул	9300	8800-9000	8100
Ямааны мах	Ястай	6800	6500	5000
	Цул	7800	7000	5400
Адууны мах	Ястай	8000	7000	5600
	Цул	8000	7500	5600

Сүү, сүүн бүтээгдэхүүн /кг, төгрөгөөр/

Төрөл	“Барс” хүнсний зах	“Бөмбөгөр” худалдааны төв	“Хүчит Шонхор” хүнсний зах
Чихэртэй ааруул /1кг/	8000	5000-10000	7000-7500
Чихэргүй ааруул /1кг/	5000	7000	6500
Сүү /1литр/	1000	1000	1000
Өрөм /1кг/	7000	6500	6500
Бяслаг /1кг/	5000	6000	4500
Эзэгий /1кг/	6000	6000	5500
Монгол масло /1кг/	4000	6000	4800
Сингапур шар тос /1кг/	3500	4000	3500

Бусад бүтээгдэхүүний үнэ /кг, төгрөгөөр/

	“Барс” хүнсний зах	“Бөмбөгөр” худалдааны төв	“Хүчит Шонхор” хүнсний зах
Цагаан будаа	1600-1800	1700-1800	1600-1800
Элсэн чихэр	1500	1500	1500

Дээрх захуудад худалдаалж байгаа хүнсний ногоо болон сүү, сүүн бүтээгдэхүүний ханш харьцангуй тогтвортой байна

Элсэн чихрийн үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.7 хувиар өссөн бол цагаан будааны үнэ өөрчлөгдөөгүй байна. /ҮСХ/

Ургамлын тос /кг, төгрөгөөр/

Ургамлын тос:	“Барс” хүнсний зах	“Бөмбөгөр” худалдааны төв	“Хүчит Шонхор” хүнсний зах
Sunny gold	2600-2800	2650-2700	2600
Олейна	3600	3600	3300
Кларина	2800	2600	2700
Янта	2700	2500	2500

СУДАЛГАА

ХЯТАД ХОРООЛОЛД ЯГ Л ХЯТАД ХҮН ШИГ МЭДРЭМЖ ТӨРДӨГ

Орчуулсан Р.ГАНТУЛГА

Нээлт: Гаднын соёл болон түүнийг илэрхийлсэн бэлгэ тэмдгийн нөлөөнд багахан автах үед тухайн соёлын үзэл санаа, төлөв байдлыг хүлээн зөвшөөрөхөд хүрдэг.

Судалгаа: Профессор Адам Алтер болон түүний хамтрагч Аризона мужийн Виржиниа Кван нар Нью-Йоркийн Хятад хороололор явж, нар, бороо сүлэлдсэн хоёр өдрийн дараа цаг агаарыг урьдчилан таамаглахаар Европ гаралтай 50 Америк иргэний дунд судалгаа явуулжээ. Харин Хятад хорооллын хүмүүсийн хувьд дэлхий буцаж эргэдэг гэсэн дорнын сэтгэлгээндээ тулгуурлан цаг агаарын өөрчлөлтийг бусдыгаа бодвол нэлээд сайн таамаглах шинжтэй байв. Нью Жерси дэх Ази хүнсний дэлгүүрээр ороод гарч явсан болон мөн ин-янийн нөлөөнд автсан Европ гаралтай америкчуудын дунд үүнтэй төстэй хандлага харагдаж байв.

Сорилт: -Иймэрхүү жижигхэн, түр зуурын соёлын төлөөлөл бидний ертөнцийг үзэх үзлийг өөрчилж үнэхээр чадна гэж үү.

-Профессор Адам Алтер: Аливаа орны соёлтой хутгалдсан тохиолдолд л танд нөлөөгөө үзүүлнэ гэж та бодож болох. Гэвч энэ нь тэр болгон үнэний хувьтай биш юм. Соёл гэгч зүйл таны бодож байгаас ч илүү хялбархан танд нөлөөлж чаддаг. Сүүлийн 15-20 жилд хөгжсөн интернэт, дэлхий дахины худалдааны өсөлт болон аялал жуулчлалын хөгжлийн ачаар бид гадныхны санаа бодол, тэднийг төлөөлсөн бэлгэдлийг илүү сайн



ойлгох болсон билээ. Бидний амьдардаг хот, суурин газрууд маш олон төрлийн бэлгэдлийн чанартай дүрс, тэмдгээр дүүрсэн байдаг. Та тэдгээрийг хүлээж авсан учраас гарцаагүй өөрчлөгддөг. Хэрвээ та Хятад хороололд ч юм уу Азийн аль нэг супермаркетэд очвол ертөнцийг Ази маягаар харах болно.

Сэтгүүл: -Та яагаад өөрчлөлтийн тал дээр анхаарсан юм бэ?

Дээрх газруудад өрнө, дорнын философийн ялгаа тод гарч ирдэг. Өрнийн хүмүүс өөрчлөлтийг гарцаагүй гэж хардаг бөгөөд гэрэл ба харанхуй гэх мэт туйлын байршлуудын хоорондох тэнцвэрт байдал тогтмол солигдон өөрчлөгдөж байдаг итгэдэг. Үүнийгээ ин-ян хэмээх дүрсээр төлөөлөн

харуулдаг. Харин дорнын хүмүүсийн хувьд иймэрхүү өөрчлөлтийг нэг чиглэл рүү дэс дараалсан хандлага гэж харах бөгөөд “урагшаа алхах” аль эсвэл “доошоо чиглэсэн эргүүлэг” гэх мэт зүйрлэлтэй холбон боддог. Бид дээрх таамаглалыг лабораторийн аргаар туршиж үзэх үүднээс Европ гаралтай Америк болон Хятад 185 хүн тус бүрт мянган ам.доллар өгч, төрөл бүрийн хувьцаанд хөрөнгө оруулах даалгавар өгсөн юм. Тэдгээрийн зарим нь даалгавраа сайн гүйцэтгэсэн боловч зарим нь базаахгүй байв. Барууныхан сайн үзүүлэлттэй гэж харж байсан хувьцаандаа мөнгөнийхөө тавиас дээш хувийг тавьсан. Харин хятадууд үзүүлэлт тааруухан байгаа ▶▶

► хувьцаануудыг ирээдүйд сайжирна гэж найдсаны үндсэн дээр мөнгөө тараан байршуулж байв.

-Хэрвээ Европ гаралтай америкчууд Хятад хороололд янз бүрийн Хятад хоол идэж, Азийн хар захаас цагаан лууван худалдаж авдаг байсан бол дээрх даалгаварт өөрөөр хандах байсан болов уу?

-Үүний гол учир нь Хятад хоол, цагаан лууванд байгаа биш гэж бид таамаглаж байна. Гэхдээ Хятадын нийгэм рүү харвал ин-ян шиг ойлгож болохуйц бэлгэдлийн чанартай дүрс, тэмдэг олон байдаг. Хятад хороололд байсан хүмүүсээс юуг хамгийн тод санаж байгааг нь асуухад янз бүрийн дүрс, тэмдэг гэж тэд хариулж байв. Эдгээр нь олон төрлийн утга, санаа агуулдаг болохыг бид бүгд мэднэ. Ямар нэг бэлгэ тэмдгийн утгыг сайн ойлгоогүй мөртлөө ихэнх тохиолдолд бид ямар ч үгнээс түрүүлээд хүлээгээд авчихсан байдаг. Харин соёл, зан заншлыг илэрхийлсэн хамгийн алдартай бэлгэ тэмдэг тухайн нийгмийн дотор ч, гадна ч олны танил болсон байдаг. Энэ тал дээр бид Нью Жерсийн худалдааны төвд худалдан авалт хийж буй хүмүүс, их сургуулийн оюутнууд болон "Wall Street"-ийн ажилтнуудыг гурван төрлийн судалгаанд хамруулсан. Судалгааг тэдний үдийн цайны үеэр явуулсан бөгөөд хувьцаа сонгох, цаг агаарыг урьдчилан таамаглах даалгавар өгсөн юм. Орлоцгоцдоос асуулт асуухаасаа өмнө ин-янийн жижиг дүрсийг асуултын хуудас болон судалгааны туслахуудын богино цамц дээр хэвлүүлж, тэдэнд албаар харуулсан юм. Заримд нь чагт, луу зэрэг дүрсийг харуулсан бөгөөд ин-янийг харсан хүмүүс бусдыгаа бодвол ямар нэг өөрчлөлтийг хүлээж байсныг бид олж мэдсэн.

-Хятадын луу ч гэсэн хүмүүсийг Хятад маягаар бодоход хүргэдэг биш үү?

-Болох юм. Гэхдээ өөрчлөлтийн тал дээр лав биш. Хоёр дахь судалгаагаар Европ гаралтай америкчуудад луугийн дүрсийг харуулсан бөгөөд Хятадын хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын өсөлт бусад орныг гүйцэж түрүүлсэн гэж тэд хэлж байв. Луугийн дүрс тэднийг Хятадын эдийн засаг өсч

байгаа гэж бодоход хүргэсэн ажээ. Гэхдээ Европ гаралтай америкчууд луугаас илүүтэйгээр ин-янийн утгыг сайн мэддэг учраас тэдний бодол санаа, үйлдэлд ин-ян илүү ихээр нөлөөлж байсныг хэлэх нь зүйтэй. Хувьцаа сонгох даалгавраар гурав дахь сорилт болох гадаадад их аялдаг, гадаад маягийн сэтгэлгээтэй хүмүүст ин-янийг харуулсан нь илүү үр дүнтэй байв. Ерөнхийдөө судалгаануудын үр дүн төстэй гарч байгаа нь харагдсан. Судалгааны хүрээнд бид хүмүүст төрөл бүрийн үнэт эдлэл үзүүлж, хэр зэрэг үнэнч болохыг нь шалгасан юм. Үнэт эдлэл дунд загалмай тавьсан байв. Христийн шашинтай хүмүүсийн хувьд загалмайн бэлгэдэл маш тодорхой, эерэг утгыг төлөөлдөг тул тэдэнд илүү нөлөөлж байгаа нь харагдаж байв.

-Тэгвэл сайн нөлөөг нь авахын тулд соёлын бэлгэдлийг сайн санаж явах хэрэгтэй юм уу?

-Үгүй. Сөрөг бэлгэ тэмдэг ч гэсэн хүнд нөлөөлдөг. Тухайлбал, хас тэмдэг хүмүүсийг маш түрэмгий болгодог. Үүний тод жишээ бол төрийн далбаа. Тухайн улсын иргэдийг нэгэн далбаан дор нэгтгэж байгаа боловч гадныхныг ялгаварладаг. Энэ тал дээр улс төрийн лидерүүд том алдаа гаргадаг гэж бодож байна. Олон улсын чанартай дээд хэмжээний уулзалтыг аваад үзье л дээ. Ихэнхдээ удирдагч нар өөрийн орны сүр хүч, бахархлын бэлгэ тэмдэг болсон туг, далбаатай гарч ирдэг шүү дээ. Нийтлэг зөвшилцөлд хүрэх зорилготой л юм бол тэднийг хувааж, талцуулах бэлгэ тэмдгүүдийг авч хаяад, оронд нь бүгдийн эв санааг илэрхийлсэн нэг төрлийн бэлгэдэлтэй байж яагаад болохгүй гэж.

-Хэрвээ би Хятад түншийнхээ санаа бодлыг мэдэхийг оролдож буй Америк бизнесмэн байлаа гэхэд ин-ян болон Хятадын бусад бэлгэдлийн чанартай зүйлсийг оффистоо тавих ёстой юу?

-Хийсэн судалгаагаа иймэрхүү өвөрмөц санал, зөвлөмж тал руу хувирагч чадах эсэхээ би сайн мэдэхгүй байна. Гэхдээ тийм байж болох юм. Хэрвээ тухайн хүнийхээ сэтгэл санааг ойлгохыг хичээж байгаа бол тиймэрхүү маягаар өрөөгөө чимэглэж, Хятад ресторанд хоол идэх ч юм уу, Хятад руу аялбал бүр ч

тохиромжтой бөгөөд аль аль орныхоо соёлын талаас утга учиртай, таатай орчинд уулзах нь бизнест илүү үр өгөөжтэй байх. Ингэснээр ядахнаа ганцхан удаа ч гэсэн дэлхий ертөнцийг адил төстэй дурангаар харж, ойлгох боломжтой. Мэдээж энэ судалгаа нь гаднын оронд байгаа бизнес эрхэлж буй хүмүүстэй чухал холбоотой. Тэдний хувьд эргэн тойронд харагдаж буй соёлыг бэлгэдсэн янз бүрийн зүйлс цаашдын үйл хэрэгт нь нөлөөлөх болно гэдгийг ойлгох хэрэгтэй.

-Ази хүмүүсийг америкчууд шиг бодож сэтгэхэд хүргэх тийм онцгой бэлгэ тэмдэг байдаг болов уу?

-АНУ маш олон бэлгэдлийн чанартай тэмдэг, тэр дундаа худалдааны тэмдэг бүхий олон бараа, бүтээгдэхүүнийг дэлхий даяар экспортолдог учраас таны асуусан зүйл тодорхой хэмжээнд болсон байх магадлалтай. Харин хамгийн ихээр нөлөөлсөн Америк бэлгэ тэмдэг юу болохыг судалбал сонирхолтой байх. Тухайлбал, Дьюк их сургуулийн судлаачид "IBM" болон "Apple" компанийн логог зурах даалгаврыг хүмүүст өгсөн бөгөөд "Apple"-ийн логог өөрийн мэдэлгүй сайн гүйцэтгэж байсныг харуулжээ.

-Латин Америк болон Африкийн хувьд юу хэлэх вэ? Бид энэ тал дээр зөвхөн хөгжилтэй орнуудын соёлын түвшинд анхаараад байна уу?

-Сэтгэлзүй болон соёлын талаарх энэхүү судалгааны хүрээнд Америк, Европыг Азитай харьцуулснаас өөр судалгаа харьцангуй цөөхөн байдаг. Үүний шалтгаан нь маш энгийн бөгөөд ихэнх судлаач эдгээр бүс нутаг амьдардагтай холбоотой гэж би таамаглаж байна

-Гэхдээ та Австрали хүн биз дээ?

-Тийм ээ. Гэхдээ би Өмнөд Африкт төрсөн, харин одоо Америкт амьдарч байна. Энэ судалгаагаа хийсний дараа бодит байдал дээр би үүнийг илүү мэдрэх болсон. Зарим орчинд би өмнөд Африк хүн шиг, зарим орчинд Австрали хүн шиг биеэ авч явдгаа би олж мэдсэн юм. Харин би удахгүй Сидней дэх гэр рүүгээ явахаар тэндхийн хүмүүс миний Америк хувилбарын талаар ярих биз. Би хамелеон шиг хүн л дээ. Ер нь бид бүгдээрээ тийм шүү дээ. ■

Эх сурвалж: *The Economist*

ЭЛЧИН САЙД

“ДОТООД ХҮЧ”

Х.ХУЛАН

Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мустафа Сарныч 2012 оны долоодугаар сараас албан үүргээ гүйцэтгэж байна. Османийн эзэнт гүрний хоёр дахь нийслэл байсан Бурса хотод төрсөн тэрбээр Анкара дахь Гази Их сургуулийн Олон улсын харилцааны ангийг 1990 онд бакалаврын зэрэгтэй дүүргэсэн аж.

-Турк улс бол тив дамнасан орон. Та эх орныхоо газар зүйн онцлогоос сонирхуулахгүй юу?

-Юуны өмнө улс төр, эдийн засгийн мэдээлэл уншдаг хүмүүст зориулан гаргадаг Монголын хамгийн сайн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэг болох танай сэтгүүлд ярилцлага өгч байгаадаа би туйлын их баяртай байна.

Манай улс Ази, Европ тив дамнасан байрлах бөгөөд Босфорын хоолойгоор зааглагддаг. Тийм учраас 750 мянган ам.метр газар нутаг дээр амьдардаг 76 сая хүн амтай Турк улс нь олон янзын соёл, шашин шүтлэгтэй хүмүүсийг холбоход ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Манайд Европ, Балканы болон Азийн улс, гүрнүүдийн шинж чанар байдгаас гадна Ойрхи Дорнод, Кавказын орнуудын онцлог мөн хадгалагдан ирсэн юм. Үүний илрэл нь бидний хоол унднаас эхлээд ардын аман зохиол, тэр ч байтугай өдөр тутмын амьдралд хүртэл тусгалаа олсон байдаг.

Түүнчлэн Туркийн Засгийн газар өөрийн хөрш орнууд болох Грек, Болгар, Сири, Ирак, Иран болон Гүржтэй харилцахдаа “Тэг бэрхшээл” буюу хамтын ажиллагааны бодлогыг баримталдаг. Сири улсад өрнөж буй хямрал нь маргаангүйгээр “Арабын хавар” хөдөлгөөнөөс улбаатай. Бид хөрш зэргэлдээ оршдог ОХУ, Азербайжан, Украин, Молдав зэрэг оронтой маш сайн харилцаатай байдаг.

-Элчин сайд аа, Та манай улсад ирэхээсээ өмнө Ойрхи Дорнод, Умард Африкийн орнууд, Аддис Абеба, Скопье, Приштина, Комитини зэрэг хотод ажиллаж байжээ. Монгол Улсад ирэхэд тань ямар үйл явдал нөлөөлсөн бэ?

-Өнгөрсөн оны өдийд шөнө дунд миний утас дуугарлаа. Утсаа автал манай Гадаад хэргийн сайд Ахмет Давутолу ярьж байна. Тэрбээр намайг Улаанбаатарт ажиллуулахаар томилсон гэдгээ хэллээ. Турк улсын Засгийн газраас миний гүйцэтгэж ирсэн албан үүргийг ийнхүү үнэлсэн нь миний хувьд үнэхээр их хүндэтгэлтэй ▶



Фотог Э.Зоригт

► үйл явдал мөн гэж үзэж байна.

Би анх удаа Азид Элчин сайдаар томилогдсон. Өмнө нь миний хашиж байсан үүрэгт албан тушаалууд ертөнцийн баруун өнцөгт байсан гэж хэлж болох юм. Амьдралынхаа сүүлийн 12 жилийг би Турк улстай түүх болон соёлын гүнзгий холбоотой гэгддэг Балканы орнуудад өнгөрүүлсэн. Энэхүү чухал албан тушаалд томилогдоход мэдээж тодорхой шалгуурууд байсан. Ололт, амжилтыг минь харгалзан үзсэн гэж ойлгож байна. Танай улсад миний гүйцэтгэх үүрэг даалгавар тодорхой улс төр, эдийн засаг, соёлын харилцааг сайжруулан, өргөжүүлэхэд чиглэсэн болно.

-Та өмнө нь ажиллаж байсан орнууддаа гаргасан өөрийн амжилт, зүтгэлээсээ хуваалцахгүй юу?

-Миний хувьд хийж гүйцэтгэсэн зүйл олон байгаа ч Косово дахь Турк-Косовогийн Худалдаа аж үйлдвэрийн танхимыг үүсгэн байгуулахад хувь нэмрээ оруулснаа мартдаггүй юм.

Энэхүү төрийн бус байгууллагын үйл ажиллагаа амжилттай явж байгаа бөгөөд өдгөө Турк, Косово хоёр улсын хооронд гүүр болж байна. Туркийн бизнес эрхлэгчдийг үүнтэй төстэй ажил танай улсад хийхийг уриалсан бөгөөд эхний алхмуудыг хийж эхэлснийг дуулгахад таатай байна.

Турк-Монгол Улс хоорондын харилцаа шинэ түвшинд хүрсэн. Тухайлбал, Улаанбаатар-Истанбулын чиглэлийн шууд нислэгтэй боллоо. Цаашид хоёр орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаанаас манай уншигчдад танилцуулахгүй юу?

Турк, Монгол Улс бараг бүхий л салбарт төгс харилцаатай хамтарч ажиллаж байна. Үүний нэг үзүүлэлт нь тун удахгүй ашиглалтад орох Туркийн Элчин сайдын яамны болон өргөөний барилгыг жишээ татаж болно. Тун удахгүй шинэ байрандаа нүүж орохоор эзэхэй байна.

Хоёр орны хамтын ажиллагаа сайн

байгаа ч олон алхмыг, нэн ялангуяа эдийн засгийн салбарт хийхээр байна. Улаанбаатар-Истанбулын чиглэлийн шууд нислэг хоёр орны эдийн засгийн хамтын харилцааны хөгжил дэвшлийг илтгэж байна. Саяхан болж өнгөрсөн Туркийн Ерөнхий сайд Рэжэп Тайип Эрдоаны айлчлалын үеэр хоёр тал нислэгийн тоог нэмэгдүүлэх асуудал дээр санал нэгдсэн. Энэ нь Монголын эдийн засгийг төрөлжүүлэхэд тус болно гэж үзэж байна.

Түүнчлэн визний асуудлыг хөнгөвчлөх журам гарсны дараа Туркээс бизнесийн төлөөлөгчид ирэх нь нэмэгдлээ. Жишээлбэл, энэ зургадугаар сард Туркийн Экспортлогчдын Холбооны төлөөлөгчид Монгол Улсад айлчилна. Өдөр ирэх тусам есөж байгаа Монголын зах зээлд асар том боломж байгаа нь харагдаж байна. Тодруулбал, Туркийн барилгын нэртэй компаниудыг Монголын орон сууц, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах тал дээр дэмжих хэрэгтэй гэж үзэж буй. ►►



Туркийн Анталья хотоос 75 км зайтай орших уран барилга, түүх дурсгалаар алдартай эртний Сийде хот

► Эцэст нь хэлэхэд, Туркийн хувийн компаниуд 20-иод жилийн турш Монголын боловсролын салбарт хөрөнгө оруулсаар ирсэн. Монголын дөрвөн хотод Туркийн таван сургууль үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд манай компаниуд хувь хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хамгийн зөв шийдэл гэж үзэж байна.

-Хоёр орны худалдааны эргэлтийн хэмжээ өнөөдрийн байдлаар 40 сая ам.доллар байгаа. Та бүхэн үүнийг 250 сая ам.долларт хүргэх зорилт дэвшүүлсэн. Худалдааны эргэлтийн хэмжээг өсгөхийн тулд ямар үйл ажиллагаа явуулахыг төлөвлөж байгаа вэ?

-Монгол, Туркийн эдийн засаг хоорондоо сайн харилцаатай бөгөөд энэ нь цаашдын хамтын ажиллагааг улам бэхжүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Хоёр орны худалдааны эргэлтийг 250 сая ам.долларт хүргэх зорилт хэт амбицтай мэт харагдах ч үүнд хүрэх бүрэн боломжтой. Монгол Улс мал аж ахуй, уул уурхайн салбартай. Манайд дэлхийд сүлжээ бүхий хүчирхэг олон компани бий.

-Та чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?

-Аливаа хүн албаны ажлаа зөв зохицуулж чадваас өөрийн хийх дуртай зүйл буюу хоббийдоо илүү их цаг зав гаргах боломжтой гэж боддог. Би хөгжим, дүрслэх урлаг сонирхдог. Тийм ч учраас Улаанбаатарт зохион байгуулагдаж буй соёлын арга хэмжээнд аль болохоор оролцохыг хичээдэг. Өнгөрсөн оны долоодугаар сард Монголд анх ирээд Богд хааны музейд зочилсон.

Нэмж хэлэхэд, би кино урлагийг ихэд сонирхдог. Боломж олдвол шинэ кино алдалгүй үзэх дуртай. Өвлийн хүйтэн өдрүүдэд ном миний хамгийн сайн найз болдог. Спортоос хөл бөмбөг, теннис тоглох дуртай.

-Турк улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн туршлагаас Та хуваалцахгүй юу. Сонгуулийн үйл явцыг шударга явуулахын тулд юуг анхаарах шаардлагатай вэ?

Юун түрүүнд Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын отгон гишүүн болсныг дурдах хэрэгтэй. Монгол Улсын Засгийн газрын урилгаар удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуулийн бүхий л үйл явцад OSCE-ын баг бүрэлдэхүүн



хяналт тавих бөгөөд бэлтгэл ажлыг хангасан. Тус байгууллагын ажиглагчид урт болон богино хугацаанд сонгуулийн үйл явцыг хянах болно. Сонгуулийг чөлөөт, шударга байдлаар явуулах ёстой. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгууль Монгол Улсын ардчилсан замналыг цаашид улам бэхжүүлээсэй хэмээн чин сэтгэлээсээ хүсч байна.

Манай орны хувьд Ерөнхийлөгчийг Туркийн парламентийн гишүүд сонгодог байсан уламжлалтай. Харин Ерөнхийлөгчийг цаашид иргэд сонгох уу, эсхүл Парламент сонгосон хэвээр байх уу гэдэг асуудлаар бүх нийтийн санал асуулга 2007 онд явуулсны дүнд олон нийтийн саналаар Ерөнхийлөгчөө сонгож байя гэж шийдвэрлэсэн юм. Тиймээс ирэх жил Турк улс Ерөнхийлөгчөө анх удаа олон нийтийн саналаар сонгох болно.

Манай хоёр улс аялал жуулчлалын салбарт хамтран ажиллахаар төлөвлөж байна. Энэ чиглэлээр ямар зорилт дэвшүүлсэн байгаа бол. Танай улсын аялал жуулчлалын салбарын онцлог юу вэ?

Аялал жуулчлал нь Туркийн эдийн засгийн гол тулгуур юм. Өнгөрсөн онд манай оронд 35 сая жуулчин аялж 25 тэрбум ам.долларын орлого улсын төсөвт оруулсан. Бид тус салбар дахь туршлагаасаа Монгол Улстай хуваалцахыг хүсч байна. Энэ талаар холбогдох түнш байгууллагуудтайгаа ярилцаж эхэлсэн. Юуны өмнө

визний асуудлыг шийдвэрлэнэ. Хоёр орны хооронд зорчих зорчигчид болон Истанбул-Улаанбаатарын нислэгийн тоог нэмэгдүүлэхийг зорьж байна. Сонирхуулахад, Туркийн аялал жуулчлалын нэлээд хэдэн байгууллага, компанийн төлөөлөгчид ирж хамтарч ажиллах төсөл судалж байгаа. Мөн "Turkish Airlines"-ийн зүгээс Монголын аялал жуулчлалын компаниудад сургалт, семинар хийхээр төлөвлөснийг дурдъя.

Турк болон Монголын түүхэн холбоосыг харахад ямар зүйл таны сонирхлыг хамгийн их татдаг вэ?

Хамгийн сонирхолтой зүйл бол Монголын газар шороон дээр Түрэг үндэстэн оршин байсныг гэрчлэх ул мөрийг харах. Хархорин сум болон Налайх дүүрэгт байрлах Түрэгийн хөшөө, дурсгалд хадгалагдан үлдсэн өвөг дээдсийн минь түүхийг унших үед Түрэгийн овгууд олон зууны туршид дорноос өрнийг зорин энэхүү урт удаан аяллаа хэрхэн хийсэн юм бол гэж би өөрөөсөө асуудаг. Тэр ч бүү хэл нүүдэлчин амьдралын хэв маягаа хадгалаад бидний өнөөгийн өлгий нутаг болох Анатолиа (Бага Ази) хүртэл нүүсэн байгаа юм. Манай улс өнөөдөр бүс нутагтаа хамгийн шилдэг улс болсны шалтгаан энэ ч байж болох юм. Мөн өвөг дээдсийн туулж өнгөрүүлсэн арвин туршлага бидэнд нэмэлт хүч чадлыг өгдөг. Энэ нь Туркийг "дотоод хүч" хэмээн нэрийддэг өөр нэг шалтгаан ч байж болох юм. ■

СТАНДАРТ

ДЭЛХИЙД ЗӨВШӨӨРӨГДӨХ АЛХАМ

Б.ЦЭЦЭЭ

Манай улс нүүрс, зэс, алт тэргүүтэй хатуу ашигт малтмалын нөөцийг Орос ах нарын жишгээр тогтоож, хэмжээг нь тооцоолж өдийг хүрсэн. Өөрөөр хэлбэл, социализмын үед ЗХУ-ын ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллыг шууд хуулсан байдаг. Энэ нь тухайн үеийн нийгэм эдийн засаг, улс төрийн тогтолцоотой уялдаж байсан ч одоо бол үгүй. 1998 онд баталж, 15 жил мөрдсөн “Ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллын түр зааврыг” өнөөдөр бид мэдэх ч олон улс үл зөвшөөрдөг. Мэргэжилтнүүдийн зүгээс ч тус түр зааврыг эрх зүйн чадамжийн хувьд тааруу, өнөөгийн

цаг үеийн шаардлагуудыг хангаж чадахгүйд хүрсэн гэж үзэж байна. Монгол Улс дэлхийн жишигтэй хөл нийлүүлэх цаг үеийн тохироо нэгэнт бүрдсэнийг эдийн засгийн тулгуур салбар болох уул уурхайн хөгжил, хөдөлгөөн харуулж буй. Энэ нь бид шинэ нөөцийн ангиллаар баялгаа үнэлж, тогтоох шаардлагатай болсон гэсэн үг.

Өнгөрсөн дөрөвдүгээр сарын эцсээр Швейцарийн Женев хотноо НҮБ-ын “Ашигт малтмалын нөөцийн ангиллын” асуудлаар мэргэжилтнүүдийн дунд ээлжит уулзалт зохион байгуулагдсан юм. Тав

дахь жилдээ болж буй тус уулзалтад 40 гаруй орны 120 гаруй төлөөлөгч оролцсон. Тухайлбал, энд ашигт малтмал, геологи хайгуул, газрын тосны үйл ажиллагаа эрхлэгч хувьцаат компаниудын төлөөлөл, хөрөнгийн биржүүд, хөрөнгө оруулагчид, тэдний эрх ашгийг хамгаалах холбоод болон холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл ирсэн байлаа.

НҮБ-ын дэргэд олон улсын хатуу ашигт малтмалын ордын нөөцийн ангиллыг 2009 онд боловсруулсан. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлөөс үүдэн дээрх ангилалд жил бүр тодорхой өөрчлөлт оруулж, »



засан сайжруулах шаардлага гарч буй. Тиймээс дээрх уулзалтын гол зорилго нь дэлхийн улс орнуудын тэргүүн туршлага, холбогдох мэргэжилтнүүдийн санаа бодлыг нэгтгэн, нөөцийн ангилалд тусгахад оршдог. Нөөцийн ангиллыг боловсруулах болсон үндсэн зорилго нь дэлхийн ашигт малтмалын баялгийн нөөцийг тогтооход нэг үндсэн шалгуур, үзүүлэлтийг барих юм.

Дэлхийд олон янзын стандарт бий. Тухайлбал Америкийн 43-101, Австрали Зүүн Өмнөд Азид JORK зэрэг нөөцийн ангиллын стандартыг нэрлэж болно. НҮБ-ын хувьд энэ бүх стандартыг нэгтгэж, ижил түвшинд аваачихыг зорьдог.

Аль нэг ашигт малтмалын ордоо дэлхийн зах зээл дээр гаргаж, хөрөнгө босгоход тухайн биржийн шаарддаг олон улсын стандартын дагуу нөөцөө тогтоож, үнэлсэн байх шаардлагатай. Энэ нь манайхны тогтоосон нөөцийн хэмжээ олон улсын хөрөнгийн биржүүдэд сонин биш гэсэн үг. Бүс нутгуудын хөрөнгийн биржийн шаарддаг нөөцийн ангиллын стандарт гэж тусдаа бий. Тухайлбал, манайд хамгийн дөт гэгддэг Хонконгийн

хөрөнгийн бирж JORK стандартыг л хүлээн зөвшөөрдөг. Монголын ангиллаар бодсон нөөцийг олон улсынхтай дүйцүүлж, манай улсын Эрдэс баялгийн зөвлөлөөс баталсан тайланд олон улс “Yes” гэж хэлэх боломжийг Олон улсын стандартаар нөөцийг тайлагнах нэгдсэн комисс CRIRSCO –д гишүүн болсноор бүрддэг. Бид НҮБ-ын зөвлөмжийн дагуу шинэ нөөцийн ангиллаа баталж, CRIRSCO үүнийг нь хүлээн зөвшөөрчихвөл манай геологичдийн гүйцэтгэж, мэргэжлийн зөвлөл баталсан нөөцийн хэмжээ, тайланг олон улсын хөрөнгийн биржүүд шууд хүлээн авна гэсэн үг. Нөгөө талаас энэ нь үндэсний геологичид, хөрөнгийн зах зээл дээр гарах гэж буй компаниуд, хувьцаат компаниудын хүсэн хүлээж байсан дэвшил.

Шинэчлэлийн Засгийн газраас энэ асуудалд онцгой анхаарч, Геологийн бодлогын хэлтэст хуучин нөөцийн ангиллыг шинэчилж, орчин үеийн 43101, JORK, НҮБ-ын жишигт хүргэхийг үүрэгджээ. Энэ оны эхэнд Уул уурхайн сайд Д.Ганхуягийн тушаалаар “Хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг

боловсронгуй болгохоор Ажлын хэсэг санал дүгнэлтээ боловсруулж сайдад танилцуулж, нөөцийн ангиллын журам боловсруулахаар ажиллаж байна. Тиймээс ч манай улсын төлөөлөл энэ жил анх удаа НҮБ-ын хурлыг зорьсон бөгөөд Уул уурхайн яамны Геологийн бодлогын хэлтсийн дарга Б.Баатарцогт, ахлах мэргэжилтэн Д.Алтанхуяг нар оролцсон. Тэдний зүгээс хурлын үеэр CRIRSCO байгууллагын хамт олонтой тусгайлан уулзаж, гишүүнээр элсэн, нөөцийн ангиллын асуудлаарх түншлэлээ эрчимжүүлэх санал тавьсан юм. Үүний хариуд комиссын зүгээс манай улстай хамтран, ОХУ-ын Нөөцийн комисс, Австралийн “Snowden” /Монголын нөөцийн асуудлыг CRIRSCO-д шилжүүлэхэд зөвлөхөөр ажиллаж буй/ компанийг оролцуулан тусгай уулзалт семинар зохион байгуулах гэж байна. Энэ нь тус байгууллагад гишүүнээр элсэхэд туулах анхны алхам аж.

Ашигт малтмалын нөөцийн ангиллын хуралд оролцсон мэргэжилтнүүдийн зүгээс зорьсон ажлаа цэгцлээд уг яамны сайдаа танилцуулчихсан аж. Одоо Д.Ганхуяг сайд баталж, нийтээр мөрдөх журам боловсруулах зэрэг асуудал үлдээд байгаа юм байна.

Нийтийн оролцоо, нийгмийн зөвшөөрлийг дэлхий онцолж байна

“Mongolian Economy” сэтгүүлийн сэтгүүлчид Женевт томилолтоор ажиллах хугацаандаа тус хурал оролцож буй Уул уурхайн яамны Геологийн бодлогын хэлтсийн дарга Б.Баатарцогттой ярилцсан билээ.

-Өнгөрсөн хугацаанд гаднын хөрөнгийн биржид хөрөнгө босгосон жишээнүүд ордын нөөцийн хэмжээ энд нэг өөр, тэнд нэг ондоо яваад байгааг гэрчилнэ. Нөөцийн хэмжээ нэг тоон дээр тогтож өгөхгүй байгаа нь түр ангилалтай холбоотой юу?

-Нөөцийн ангиллыг олон улсын жишигт нийцүүлэх гэж байгаагийн гол зангилаа нь энэ. Монголын ангиллаар нэг тоо, JORK, 43-101 стандартаар тооцоолбол өөр нэг нөөцийн хэмжээ»



► гарчихаад, хоорондоо зөрдөг. Энэ бол манай мөрдөж буй түр ангилал, гаднын хөрөнгийн биржүүдийн дагадаг ангиллын хооронд зөрүү байгааг харуулж байгаа.

Бидний зүгээс мөн уламжлалт бус ашигт малтмалын нөөцийг хэрхэн тогтоох вэ гэдэг асуудлыг цэгцэлж, гаргахаар төлөвлөж байна. Нөгөө талаас Монголын хөрөнгийн биржтэй нягт хамтарч ажиллахаар төлөвлөж байгаа. Үнэт цаасны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хөрөнгийн биржид хувьцаагаа арилжаалах сонирхолтой компаниудтай бидний хийж байгаа ажил нягт уялдана. Монгол Улсын нутаг дээр хайгуул хийгээд, баялгаа тогтоосон л бол бидний хийж буй шинэ ангиллын дагуу нөөцөө тооцоод, хөрөнгийн биржид IPO хийх эрх зүйн боломж бүрдэж байна. Улмаар цаашаа олон улсын зах зээл рүү гарах боломжтой.

-НҮБ-аас тогтоож буй энэ зөвлөмжийг стандарт гэж ойлгож болох уу, Олон улсын хөрөнгийн зах дээр хөрөнгө босгоход тус ангиллаар тогтоосон нөөцийн хэмжээг хүлээж авах уу?

-Стандарт гэж хэлж болно. НҮБ-аас энэ ангиллыг заавал мөрд гэж зааварчилдаггүй. Учир нь энэ нь зөвлөмж. Улс орнууд ашигт малтмалын нөөцөө өөрсдийн онцлогт тохируулан ангилахаар дараа нь нэг системд оруулж, нэгдсэн тоо гаргах үед хоорондоо уялдахгүй байх асуудал тулгардаг. Энэ асуудлыг шийдвэрлэхэд дээрх ангилал чиглэж буй.

Зөвхөн НҮБ-ын нөөцийн ангиллыг ашигласан тохиолдолд хүлээн зөвшөөрнө гэдэггүй. Бүс нутгийн хөрөнгийн захуудын шаардлага ондоо. Тухайлбал, Австрали, зөвхөн JORK стандартыг шаарддаг. Гэвч өнгөрсөн жилээс Австрали тэргүүтэй Зүүн Өмнөд Азийн хөрөнгийн биржүүд Хойд Америкийн стандартыг хүлээгээд авчихсан. Улсууд бие биенийхээ стандартыг хүлээн зөвшөөрнө гэдэг ижил түвшинд очиж, ялгаа нь багасч буйг харуулж байгаа. НҮБ-ын хувьд аль ч оронд хүлээн зөвшөөрөгдөх нэг стандарттай болох санаачилгыг хэрэгжүүлж байна. Үүний цаана хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах бодлого, тухайлбал, хөрөнгө оруулагчид, Засгийн газар, хувьцаа эзэмшигчдийг хамгаалсан дүрэм журам бий. Хэн нэгэн 20 тонн алттай орд оллоо гэхэд итгэх үндэслэл хэрэгтэй. Тэгвэл тийм хэмжээний нөөц байгааг тогтоож, хөрөнгө оруулагчид итгэл үнэмшил төрүүлэх баталгаа нь энэхүү нөөцийн ангилал юм. Шинэ ангилал ашиглаад ирэхээр бид олон улсын жишгийн дагуу газар доорх баялгаа тооцно. Ингэхээр хөрөнгө оруулагчдын итгэл ч нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

-Шинэ ангиллаар эдийн засгийн үр ашигт ямар өөрчлөлт орох вэ ?

-Одоогийн мөрдөж буй ашигт малтмалын нөөцийн ангиллын дагуу газрын гүнд байгаа геологийн нийт нөөцийг зарлаж өдийг хүрсэн. Гэтэл гаднынхан олборлож болох нөөцийг зөвхөн ашигт малтмалын нөөц гэж хүлээн зөвшөөрдөг. Тиймээс нэг талаас манай ангиллын дагуу тогтоосон нөөцийн хэмжээ харьцангуй өндөр гардаг. Харин шинэ ангиллаар нөөцийн тооцоололд ордыг ашиглах аргачлал, техник эдийн засгийн үндэслэл, уул техникийн нөхцөл зэрэг олон нэмэлт үзүүлэлтийг харгалзаж үзнэ. Ингэснээр өнөөгийн техник технологи, зардал, дэд бүтцийн боломжид тулгуурлан олборлож болох бодит нөөцийн хэмжээ гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, газрын хэвлийд хэчнээн арвин нөөц байлаа ч түүнийг олборлох технологийн арга байхгүй бол түүнийг нөөц гэж үзэхгүй. Харин баялаг гэнэ.

-Энэ удаагийн Нөөцийн ангиллын хурал ямар асуудлуудыг голчлон хөндсөн бэ?

-Тус хурлаар “Нийгмийн зөвшөөрөл” хэмээх сүүлийн үеийн чиг хандлагыг онцолж ярилаа. Тухайн бүс нутгийн олон нийтээс зөвшөөрөл авах нь нөөц мөн эсэхэд харгалзах үзүүлэлтүүдийн нэг. Хөшөөтийн ордын нөөцийг тогтоочихсон, ашиглахад бэлэн гэж бодъё. Гэтэл нутгийн иргэд ордоо ашиглуулахаас дургүйцэж, Нийгмийн зөвшөөрөл өгөхгүй бол үүнийг хөрөнгийн бирж нөөц гэж үзэхгүй. Улмаар мөнгө босгох боломжгүй. Эдийн засаг, нийгэм, байгаль орчин зэрэг олон асуудлын хүрээнд цаад үр дагаврыг нь тооцож байна гэсэн үг. Дээрх асуудалтай уялдан “Local content” буюу нутгийн оролцоог ихээхэн чухалчлах асуудал гарч ирж байгаа. Энэ нь томоохон төслүүдийн хүрээнд нутгийн уугуул иргэдэд гол болоод туслан гүйцэтгэгч байгууллагуудад ажиллах давуу эрхийг хэрхэн бүрдүүлснийг мөн харгалзах асуудал байв.

Тус хурлаар яригдсан дараагийн чухал асуудал нь уламжлалт бус ашигт малтмалыг хэрхэн үнэлж, нөөцийг нь тооцох юм гэдэг байлаа. Тухайлбал, занарт агуулагдах газрын тос, фосфоритын хүдэр, нүүрс, газрын ховор элементэд агуулагдаж байгаа тодорхой хэмжээний ураны хэмжээг хэрхэн тооцож, нөөцийг нь тогтоож, бүртгэх талаар хэлэлцсэн. Мөн ордыг мөнгөн дүнгээр илэрхийлэх үнэлгээний асуудал хурцаар тавигдлаа. Тухайн ордын газрын гүнд байгаа ашигт малтмалыг ямар үзүүлэлтүүдээр үнэлэх вэ гэдэг юм. Техник, эдийн засаг, геологийн олон асуудалтай уяж гаргаж ирэхээр ярилцаж байна. ■

Газрын хэвлийд хэчнээн арвин нөөц байлаа ч түүнийг олборлох технологийн арга байхгүй бол түүнийг нөөц гэж үзэхгүй. Харин баялаг гэнэ.

ОЮУТОЛГОЙН БУЛАН

ХӨГЖЛИЙН ЗУРАГЛАЛ



Б.АЛТАЙ

Дэлхийн зэсийн томчуулын тоонд Монгол бичигдээгүй ч Оюутолгой Эрдэнэттэй нийлбэл дэлхийн зэсийн нөөцийн 10 хувийг эзэлнэ хэмээн “Оюутолгой: эрт, эдүгээ, ирээдүй” номонд онцолжээ.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 15 жилд урьд өмнө байгаагүйгээр огцом өсчээ. Энэ хугацаанд ДНБ нэрлэсэн дүнгээрээ 10 дахин, бодит дүнгээрээ хоёр дахин өсөв. Улаанбаатар хотын төсөв гэхэд л 15 дахин нэмэгдсэн байх жишээтэй.

“The Economist” сэтгүүлийн эдийн засгийн өсөлтийн хурдаараа энэ онд тэргүүлэх 10 орны жагсаалтад Монгол Улс багтаж, бүр өнгөллөө. Түүхэнд тэмдэглэх эдийн засгийн өсөлт Оюутолгойн төслийн бүтээн байгуулалтаар идэвхжиж, Монгол Улс “зэрэг нэмлээ”. Энэ нь бага орлоготой орны тооноос хасагдаж, дундаж орлоготой орны тоонд багтсан явдал юм.

Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ өнгөрсөн хугацаанд дөрөв дахин өсч, сүүлийн дөрвөн жилээр аваад үзэхэд эдийн засаг нийтдээ 90 гаруй хувиар тэлж, “супер”

өсөлттэй орны тоонд толгой цохиж явна. Тавантолгой, Оюутолгой төсөл Монгол Улсын хөгжлийн зураглал гэхэд дэгсдэхгүй болов уу. 2020 он гэхэд Оюутолгой төслийн нөлөөгөөр манай улсын эдийн засаг 35 хувиар өсч, бодит ДНБ 14 хувиар тэлэх нь. Тухайлбал, алтны үйлдвэрлэл долоон жилийн дараа гэхэд 25 сая тонн хүртэл өсч, уул уурхайн үйлдвэрлэл “зиндаа” ахих нь.

Төсвийн алтан найдвар, экспортын голлох бүтээгдэхүүн болох цэвэр зэсийн үйлдвэрлэл гурав дахин нэмэгдэх аж. 2017 онд манай улс 60 тонн цэвэр зэс үйлдвэрлэх бол 2040 онд дээрх хэмжээ 150 мянган тонн хүрнэ гэж “Оюутолгой-Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ” судалгаанд тэмдэглэжээ. Зөвхөн алт, зэсийн үйлдвэрлэл тэлээд зогсохгүй коксжуулсан нүүрсний үйлдвэрлэл дөрөв дахин өсч, өнөөдрийн таамгийг эвдэх бололтой.

Өөдрөг хүн амжилтад хүрдэг гэдэг. Тэгвэл манай орны бодит ДНБ 30 жилийн дараа 57.76 их наяд төгрөг болж, жилд дунджаар 6.3 хувиар өснө гэсэн таамаг судалгаа гарчээ. Тус судалгаанд өгүүлснээр Оюутолгойн орд газраас олох орлогыг хөрөнгө хуримтлуулах санд байршуулах нь эдийн засгийн үр ашигтай. Харин төслөөс олох орлогыг айл өрхүүдэд бэлнээр тарааснаар эдийн засгийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө гэжээ.

Уул уурхайн салбарт гаднын хөрөнгө оруулалт ►►



Оюутолгойн Баяжуулах үйлдвэрийн хүдэр хадгалах байгууламж

▶ нэвчсэн оргил үе хэдий саарсан ч эдийн засаг өссөөр. “Ядарсан орон гадаадын хөрөнгө оруулалтаар л босч ирдэг. Эхэлж хөдөлгөх капиталгүй учраас шүү дээ. Япон, Солонгос, Тайвань зэрэг өнөөгийн хөгжингүй орнууд дайны дараа Америкийн хөрөнгө оруулалтаар өндийсөн” хэмээн нийтлэлч Баабар хэлжээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээгээр манайд 2011 онд 10 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн байна. Үүний 74 хувь нь геологи, уул уурхайн салбарт ногдох аж.

“Зэсийн ханш хэчнээн уруудсан ч гандан буурахгүй. Учир нь зэс шүү дээ” хэмээн “Эрдмин” үйлдвэрийн үүсгэн байгуулагч, зөвлөх Ж.Дамдинжав хэлж байсан. Урд хөршийн зэсийн импорт өнгөрсөн улиралд 100 мянга орчим тонноор багассан ч сэтгэл гонсойход эрт. Сүүлийн 113 жилийн хугацаанд зэсийн үнийн өсөлт, бууралт ээлжлэх ч бүхэлдээ өссөөр иржээ. Тун удахгүй дэлхийн зэсийн зах зээлд Монгол Улс Оюутолгой хэмээх отгон гишүүнээ “танилцуулна”.

Зарим хүмүүс “Оюутолгой” компанийг татвар төлдөггүй гэж цуурдаг. Гэтэл өнгөрсөн онд нийт 280 сая ам.долларын татвар, хураамжийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

“Оюутолгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн асан Ч.Ганболд “Өнөөдрийн

өндөрлөг хүртэлх бүх үйл явдал нүдний минь өмнө болсон гэж болно. Намайг анх Оюутолгой гэдэг газар очиход арваад гэртэй кэмп байсан. Өнөөдрийн энэ том бүтээн байгуулалт бостлоо урт замыг туулсан. Оюутолгойг зөвхөн орон нутгийнхан л мэддэг байсан тэр ойлголтоос өнөөдөр халиад, дэлхий нийтээр, сайн мэддэг, хөрөнгө оруулагчид, банкны салбарынхан сонирхдог том төсөл болтлоо хосгүй түүхийг туулсан гэж би үздэг” хэмээн “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлагадаа онцолжээ.

Оюутолгойн зэсийн баяжмал товлосон өдрөө хилийн дээс алхаагүй ч тун удахгүй экспортод гарна. Уул уурхайн дэд сайдын хэлснээр “Оюутолгой” компани энэ жил 300-500 мянган тонн зэсийн баяжмал экспортлохоор төлөвлөжээ. Гэхдээ дээрх хэмжээнд хүртэл бүтээгдэхүүнээ экспортлох эсэх нь баяжмал зөөх авто зам, боомтын нэвтрүүлэх хүчин чадал зэргээс шалтгаална хэмээн Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Отгочулуу хэллээ.

Нийт үнэлгээ нь 440 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний алт, зэсийн нөөцтэй Оюутолгой орд өнөө цагийн мөнхийн сэдэв болсоор. Хөгжиж буй орны хөдөлгүүр учраас Оюутолгойн “цаг агаар” Монголын эдийн засагт ган тайлсаар байх нь ээ. ■

**MONGOLIAN
ECONOMY**

**СЭТГҮҮЛИЙН РЕАКЦИА
БАЙНГА ЗАХИАЛГА АВНА**
Хүргэлж үнэгүй

Хаяг:

Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг IV хороо,
Анкарагийн гудамж-23,
Тод Тауэр-604 тоот

Утас: 7011-5476

9409-2904

9409-2905

9409-2906

Сэтгүүл захиалгын үнэ	15.000₮
Улиралд 6 дугаар	90.000₮
Хагас жилд 12 дугаар	180.000₮
Жилд 24 дугаар	360.000₮
Борлуулалтын үнэ:	18.000₮





НОГООН
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**НОГООН
ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ**